

MEC

MONGOLIA ENERGY CORPORATION

М о э н к о Х Х К

**ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “МОЭНКО”
ХХК-ИЙН ХӨШӨӨТИЙН НУҮРСНИЙ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСӨЛ
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: (MV-001414A, MV-001640A, MV-006525A, MV-004322A, MV-011887A, MV-020299A, MV-011888A, MV-015289A)

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5141583

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын Ахлах мэргэжилтэн...../Ц. Жаргалнэмэх/

Биелэлтийг тайлагнасан:

“МОЭНКО” ХХК-ийн Дэд захирал...../Ж.Оюунчимэг/

“МОЭНКО” ХХК-ийн ХАБЭАБОС-ын Менежер...../Б.Эрдэнэбилэг/

2022 он

**ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “МОЭНКО”
ХХК-ИЙН ХӨШӨӨТИЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСӨЛ
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: (MV-001414A, MV-001640A, MV-006525A, MV-004322A, MV-011887A, MV-020299A, MV-011888A, MV-015289A)

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5141583

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын Ахлах шинэжээч:...../Ц. Жаргалнэмэх/

Биелэлтийг тайлагнасан:

“МОЭНКО” ХХК-ийн Дэд захирал:...../Ж.Оюунчимэг/

“МОЭНКО” ХХК-ийн ХАБЭАБОС-ын Менежер:...../Б.Эрдэнэбилэг/

ГАРЧИГ

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	vi
ОРШИЛ	1
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 Ордын нөөц.....	6
1.3 Дэд бүтэц.....	7
1.4 Нүүрс олборлолт, ил уурхайн хүчин чадал.....	9
1.5 Нүүрс баяжуулах технологи, тоног төхөөрөмж	10
1.6 Өрөмдлөг, тэсэлгээний ажил.....	11
1.7 Уурхайн тээвэр	11
1.8 Ил уурхайн үндсэн хэмжээс, загварчлал.....	11
1.9 Усан хангамж.....	12
1.10 Ашигласан усны хэмжээ.....	15
1.11 Ажиллах хүчний тухай мэдээлэл.....	19
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	20
2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц.....	27
2.3 Хөрсөн бүрхэвч газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт	28
2.4 Амьтны аймаг	31
2.5 Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбайд үүсэх тоосжилт бий болохоос сэргийлж тоос дарагч мананжуулагч машиныг үргэлжлүүлэн ашиглана.	32
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
3.1 Биологийн нөхөн сэргээлт.....	34
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36
4.1 Дүйцүүлэн хамгаалах нэмэлт ажил	39
4.2 Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжих урт хугацааны төлөвлөлтийн хүрээнд хийгдэх ажлууд.....	44
Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх	44
4.3 МоЭнКо ХХК-ийн хэрэгжүүлэх нэг сая мод хөтөлбөр	47
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	50
ЗУРГАА. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	52
6.1 Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэлжүүлэх	53
6.2 Уурхай орчмын түүх дурсгалын газруудад самбар хийх	55
ДОЛОО. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	56
7.1 Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах	58
7.2 Ариутгал халдваргүйтгэл хийх	59
7.3 Шатах тослох материалын тосох, зөөх савыг нэмэгдүүлэх	59
7.4 Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах, галын хор болон самбар нэмэж байрлуулах	59

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	60
8.1 Ахуйн хог хаягдал	68
8.2 Үйлдвэрийн хог хаягдал	72
8.3 Аюултай хог хаягдал.....	74
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	75
9.1 Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ.....	79
9.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	90
9.3 Хөрсний судалгаа	98
9.4 Амьтан, ургамал	100
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	101
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	103
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	105
ХАВСРАЛТ 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар	106
ХАВСРАЛТ 2. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн зарцуулсан химийн хортой болон аюултай бодисын ашиглалтын дүн мэдээ	161
ХАВСРАЛТ 3. Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээг хэрхэн гүйцэтгэснийг нотлох гэрэл зураг	166
ХАВСРАЛТ 4. Хийж гүйцэтгэсэн ажлын акт.....	170
ХАВСРАЛТ 5. Хуваарьт болон хуваарьт бус аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	193
ХАВСРАЛТ 6. БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ.....	196
ХАВСРАЛТ 7. Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл.....	199
ХАВСРАЛТ 8. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас	206
ХАВСРАЛТ 9. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар	207
ХАВСРАЛТ 10. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар	218
ХАВСРАЛТ 11. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар.....	219
ХАВСРАЛТ 12. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний мэдээ.....	249
ХАВСРАЛТ 13. БОМТ Барьцаа мөнгөний баримт	250

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөшөөтийн нүүрсний ордын байршлын зураг.....	3
Зураг 2. Тоног төхөөрөмжийн холболтын бүдүүвч	10
Зураг 3. Ил уурхайн ашиглалтын эцсийн байдал.....	12
Зураг 4. Well-2 худаг, суурилуулсан усны тоолуур	12
Зураг 5. WDH-03 шавхалтын худаг, суурилуулсан усны тоолуур	13
Зураг 6. Худагт суурилуулсан ус ашиглалтын хяналтын камер	13
Зураг 7. Ус зөөвөрлөх машиныг зориулалтаар нь ялгасан байдал	14
Зураг 8. Нүүрс тээврийн машины хучлагын хэсгийн ажиллагаа.....	25
Зураг 9. Уурхайн технологийн зам усалгаа	25
Зураг 10. АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 багажаар хурд хэмжигч багаж	26
Зураг 11. Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ.....	27
Зураг 12. Шүүрлийн усны дээж авалт	27
Зураг 13. Уст цэгүүд орчмын хог хаягдлын цэвэрлэгээ	28
Зураг 14. Хаягдал тос масло түр хадгалах цэг.....	28
Зураг 15. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл, ашигатай бичил биетний биобэлдмэл EM-1	29
Зураг 16. Хуулсан шимт хөрс тээвэрлэлт.....	29
Зураг 17. Шимт хөрснөөс авч оффис орчимд ногоон байгууламж байгуулсан.	29
Зураг 18. 2022 онд хуулсан шимт хөрсний хэмжээ.....	30
Зураг 19. Цэцэг сум Зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ.....	31
Зураг 20. Нүүрсний талбайд ажиллаж байгаа мананжуулагч машин.....	32
Зураг 21. Хуурай баяжуулах үйлдвэр, экспортын нүүрс ачилт, буулгалтын талбай.....	32
Зураг 22. Шимт хөрсний талбайд олон наст ургамалын үр тариалсан	34
Зураг 23. Шимт хөрсний талбайд хадгалагдаж байгаа шимт хөрсний хэмжээ	34
Зураг 24. Үенч сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ	46
Зураг 25. Дарви сум ойжуулалт.....	48
Зураг 26. Цэцэг сум ойжуулалт	48
Зураг 27. Булган ум ойжуулалт	49
Зураг 28. Алтай сум ойжуулалт	49
Зураг 29. Нөлөөллийн бүс дэх өвөлжөө, хаваржааны судалгаа.....	51
Зураг 30. Дугуй хүрээтэй овгор дараастай хиргисүүр 2010-2022 он.....	53
Зураг 31. Дугуй хүрээтэй хиргисүүр 2010-2022 он	53
Зураг 32. Хүрээгүй дугуй чулуун овоолго бүхий байгууламж 2010-2022 он.....	54
Зураг 33. Хүрээ, дагуул байгууламжгүй хиргисүүр 2010-2021 он	54
Зураг 34. Хөшөөт 114: Дугуй хүрээтэй нэг хиргисүүрийг хамгаалсан	54
Зураг 35. Үенч суманд байрлуулсан самбар	55
Зураг 36. Цэцэг суманд байрлуулсан самбар.....	55
Зураг 37. Химийн бодисын хадгалалт	57
Зураг 38. Лабораторийн шинжилгээний үйл явц	57
Зураг 39. Химийн бодисын агуулахад байрлуулсан асгаралтаас хамгаалах иж бүрдэл.....	58
Зураг 40. Ариутгал халдваргүйжүүлэлт	59
Зураг 41. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл.....	59
Зураг 42. Аюултай хаягдлын ангилан ялгалт	63
Зураг 43. Хог хаягдлын нийтийн цэвэрлэгээ	68
Зураг 44. Уурхайн ахуйн хог хаягдлын ангилан ялгалт	69
Зураг 45. Бохирын машин.....	70
Зураг 46. Хуванцар сав ангилан ялгалт	71
Зураг 47. Нүүрс тээврийн зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээ	72
Зураг 48. Нүүрс тээврийн зам дагуу байрлуулсан бие засах газар, хурд сааруулагч	73

Зураг 49. Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдлыг дахин ашиглаж байна.....	73
Зураг 50. Эмнэлэгийн хог хаягдлын бүртгэлийн маягт	74
Зураг 51. Усны ерөнхий химийн шинжилгээний дээж авч буй байдал	79
Зураг 52. Үенч сумын төвийн худаг /Ерөнхий химийн шинжилгээ/.....	80
Зураг 53. Булган гол /Ерөнхий химийн шинжилгээ.....	80
Зураг 54. Уст цэгүүдийн хүнд металлын шинжилгээ	81
Зураг 55. Гадаргын болон газар доорхи усны мониторинг хэмжилт	83
Зураг 56. Усны дээж авах хяналтын цэгийн байршил	84
Зураг 57. Гадаргын болон газар доорх усны хэмжилтийн багаж.....	85
Зураг 58. Хөшөөтийн уурхайн усны мониторинг хэмжилтийн цэгийн байршил	86
Зураг 59. Булган гол усны хэмжилт, дээж авалт	89
Зураг 60. Үенч сумын төвийн худаг, ГХТ ашиглалтын худаг	89
Зураг 61. Үенч голын хэмжилт, усны дээж.....	89
Зураг 62. Ногоон титэм ХХК агаарын чанарын судалгаа.....	91
Зураг 63. Төслийн талбайн дуу шуугианы хэмжилт	92
Зураг 64. Тоосонцор хэмжилтийн DustTrack багаж	93
Зураг 65. Дуу шуугианы түвшин, салхины хурд хэмжигч багаж	95
Зураг 66. Тоосонцор, дуу шуугианы мониторинг хэмжилт	95
Зураг 67. Тоосонцор дарагч мананжуулагч машин.....	96
Зураг 68. Тоосжилт бууруулах салхины хурдыг сааруулах 12 метр өндөр торон хашаа.....	96
Зураг 69. Уурхайн технологийн зам усалгаа	97
Зураг 70. Ажлын байрны эрүүл ахуйн хэмжилт.....	97
Зураг 71. Хөрсний дээж авах ажиллагаа	98
Зураг 72. Хөрсний мониторингийн цэгийн байршил.....	99
Зураг 73. Дарви сум биотехникийн арга хэмжээ.....	100

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл	4
Хүснэгт 2. Төслийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	5
Хүснэгт 3. Ордын нөөц (B+C).....	6
Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээс	11
Хүснэгт 5. Унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг тооцсон байдал).....	15
Хүснэгт 6. Хөшөөтийн уурхайн 2022 оны жилийн ашигласан усны хэмжээ, 09 дугаар сарын 30 -ны байдлаар	17
Хүснэгт 7. Хөшөөтийн уурхайн 2022 оны жилийн ашигласан шүүрлийн усны хэмжээ, 09 дугаар сарын 30 –ны байдлаар	18
Хүснэгт 8. Ахуйн хог хаягдлын төрөл ба зохицуулалт	62
Хүснэгт 9. Аюултай хог хаягдлын төрөл ба зохицуулалт	63
Хүснэгт 10	87

ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

Байршил. Хөшөөтийн чулуун нүүрсний орд нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд оршино.

Үйл ажиллагаа. “МоЭнКо” ХХК-ийн “Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төсөл нь нийт 1885.02 га талбайг хамарсан MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299 тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрөлтэйгээр нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байна. Нарийвчилсан хайгуулаар 88.91 сая тн нүүрсний нөөц тогтоосноос уурхайн хил хязгаар дотор 84.58 сая тн, үйлдвэрлэлийн нөөц 84.36 сая тн бөгөөд 25 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн.

Газрын гадарга, хэвлий. Хөшөөтийн чулуун нүүрсний орд нь Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойт хэсэгт далайн түвшнээс дээш 1900-2250 м өндөрт орших бөгөөд урд талаар Зүүн даваа /д.т.д 2055.0 м/, баруун болон зүүн, зүүн хойд талаараа далайн түвшнээс дээш 2136-2202 м-ийн өндөрт өргөгдсөн хурц биш бөмбөгөр оройтой дундаж өндөр уулс (Хойт хамар), тэдгээрийн хоорондох нарийн давчуу ам, жалга ихтэй ба энэ орчимд хуучин уурхайн эдэлбэрт ашиглагдаж байсан карьер бүхий талбайнууд байрлана.

Уур амьсгал. Төслийн талбай оршиж буй Дарви сум нь уулсын бэлээс уулсын хоорондох Их нууруудын хотгорын өмнө хэсгийн Зэргийн хоолойн хуурайдуу-хүйтэн, сэрүүн уур амьсгалтай. Агаарын дундаж температур өвлийн хамгийн хүйтэн 1 сард уулархаг хэсэгтээ -20...-23 градус, хамгийн дулаан 7 сард 17-19 градус байх ба жилийн дундаж агаарын температур 0...+2 градус байдаг онцлогтой. Жилдээ 100-205 мм хур тунадас унадаг. Нарны цацраг, гийгүүлэл нь тухайн өргөргөөс дээшлэх дэд мужаас нэмэгдэж нийлбэр цацраг 5050-5070 мДж/м², нарны шууд цацраг 3050-3080 мДж/м² хэмжээтэй ирж нарны илч, цацраг дээрх дэд мужуудаас нэмэгдэж байдаг. Нарны гийгүүлэл жилдээ 2950-3020 цаг, үүнээс 12 сард 160-180 цаг, 5 сард 290-300 цаг үргэлжилдэг. Энэ дэд муж нь салхи шуурга ихтэйгээс элс шорооны нүүдэл салхины хүчээр нүүдэллэн зөөгдөх, цастай үед цасан шуурга тавих, зун хуурайших гандах, бас аадар эрчимтэй орох үед үерлэх, халууны нөлөө үйлчлэл багагүй байдаг.

Агаарын чанар: Хөшөөтийн уурхай орчимд 2019 оны 11 дүгээр сарын 02-05 өдрүүдэд хийсэн агаар дахь бохирдуулах бодисыг тодорхойлох хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд нүүрсний уурхай орчмын агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламж Монгол улсын Агаарын чанарын стандарт (MNS 4585:2016) дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй. Харин агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж уурхайн оффис, Хөшөөтийн гол орчим бусад цэгээс арай илүү ажиглагдсан бол хамгийн бага агууламж нь алслагдсан бүс болох МТ шатахуун түгээх станц, Тахилтын булаг орчим байсан байна.

Гадаргын ус: Төслийн талбай орчмын газар нутаг нь гадаргын ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсгалгүй ай савд буюу Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газарт багтдаг. Энэ нь монгол орны баруун хэсэг Алтайн нурууны салбар уулс мөнх цаст Сутай хайрханы зүүн доод амнууд болох Хөндлөн, Мухар, Дэнгийн ам нь Хөшөөтийн голын ай савыг дамнан оршино. Өндөр уулын хур тунадасны тэжээмжээр бүрдэх гадаргын урсац уулын хажуу, бэлийн сэвсгэр хурдсанд шургаж, улмаар уулс хоорондын хөндийгөөр булаг болон илрэх түгээмэл зүй тогтол энэ нутагт илэрдэг. Энэ бүс нутгийн хувьд горхи, жижиг булаг голууд байх ба тэтгэмжээ уулсын 2000 м-ээс дээш өндөрт буух хур тунадас, мөстөл, мөсөн голуудын мөсний хайлсан уснаас авдаг.

Уурхайн зүүн хойгуур 3 км орчим зайтай гадаргын усны томоохон урсац болох Хөшөөтийн гол баруун хойш чиглэн урсдаг ба голын ус 5-7 км-ийн зайд голын хөндийн нарийссан хэсэгт Тахилтын булаг, Түвшин буурын рашаан зэрэг гадаргын ус илэрнэ.

Хөшөөтийн голын усны түвшин хэвийн хэмжээтэй үед усны өнгөрөлт 12,0-35,0 л/с байдаг. Хөшөөтийн голын хөндийн өргөн 500-800м юм. Жилийн дундаж урсац 0,79-1,46 м³/с-ийн хооронд хэлбэлздэг. Хөшөөтийн гол нь Сутай хайрханы мөнх цаснаас эх авч урсдаг, хур бороотой жил, цөөхөн сар түр урсгалтай, гантай жил урсацгүй болдог. Голын гольдрил нарийн, унал ихтэй, голын эх рүүгээ цэвдэг хөрстэй. Хөшөөтийн нүүрсний уурхай орчимд голын гольдрил 180-240 м болж өргөсдөг ба ихэнхдээ тасарч, зарим газраар булаг байдлаар урсдаг.

Газрын доорх ус: Төслийн талбайд хийсэн судалгаагаар гидрогеологийн хувьд таатай нөхцөлтэй, шүүрлийн ус багатай буюу уурхайн үйл ажиллагаа явуулахад газрын доорх усны илэрц бага байна. Ордын геологийн тогтоцтой уялдан энд нүх сүв, ан цавын коллекторууд байх бөгөөд газар доорх усны ангиллаар нүх сүв, ан цавын дэд төрлийн ус тархжээ.

Дөрөвдөгч галавын настай пролюви-делювийн болон аллювийн гаралтай хурдсанд тархсан чөлөөт гадаргатай нүх сүвийн ус ихэнхи хэсгээр 6.5-18.7м гүнээс илрэх бөгөөд хур тунадасны нэвчэлтээр талбайн тэжээмж авахаас гадна палеозойн үндсэн суурь чулуулгийн массиваас ирэх газар доорхи алсын урсацаас тэжээгдэнэ. Энэхүү уст давхаргад гаргасан худгийн ундрага 0.3-2.8 л/с, хувийн ундрага нь 0.1-0.4 л/с 1м байгаа нь харьцангуй усжилт багатай болохыг харуулна. Гэвч төслийн талбайд бага хэмжээний шүүрлийн ус ажиглагдаж байна.

Хөшөөтийн нүүрсний уурхайн ус хангамжийг Хөшөөт голын хөндийд 2008 онд өрөмдсөн Well-1(ундарга-6.6л/сек), 2009 онд өрөмдсөн Well-2 (ундарга-9 л/сек), 2012 онд гаргасан РВ-3 (ундарга-6 л/сек) өрөмдмөл худгуудаас хангах бүрэн боломжтой юм. 3 худгийн усны ундарга нийт 25.6 л/сек бөгөөд Хөшөөтийн уурхайн боломжит нөөцийг Усны нөөцийн зөвлөлийн 2013 оны 05-р тогтоолоор 18.5 л/с-ээр буюу хоногт 1598.4 м³-ээр тогтоосон. Мөн уурхайд орж болзошгүй усыг Уул уурхайн хүрээлэнгээс баталсан уурхайн ТЭЗҮ-д тооцсоноор газрын доорх усны нийт хэмжээ 825.25м³/хоног буюу 76.05м³/цаг байна. Зам талбай болон биологийн нөхөн сэргээлтийн усалгааг шүүрлийн усаар хангахаар төлөвлөсөн.

Хөрсөн бүрхэвч: Хөшөөтийн нүүрсний уурхай нь Хөрс-газарзүйн мужлалтаар Говийн их муж, өндрийн бүшилтэй Монгол Алтайн дэд мужийн Монгол Алтайн 51-р тойрогт хамаарах ба уурхайн эдэлбэр газрын хэмжээнд уулын болон хөндийн, нугын хөрс зонхилон тогтворжиж хөрсний 8 хэв шинж, дэд хэв шинж тархсан байна. Эдгээрээс элсэнцэр хар хүрэн хөрс тархсан хэсэгт уурхайн 2021-2025 оны үйл ажиллагаа явагдаж нийт 52.85 сая м³ хөрс хуулна. 2020 оны байдлаар уурхайн нийт талбайн 11.47 хувь буюу 330.92 га талбайн хөрс олборлолт, ашиглалтаар эвдэрч, талхагдсан байна. Хөшөөтийн нүүрсний орд газрын хэмжээнд хөрс хортой бодис, элементээр бохирдож доройтоогүй тул хөрсний чанар хөрсөнд агуулагдах хүнд элементийн агууламжаар хөрсний чанарын стандартын түвшинд байна.

Ургамлан нөмрөг: Уурхай орчмын нутаг нь хуурай уур амьсгалтай жилийн болон хоногийн температурын агууриг их, хур тунадас бага ордог тул хөрс нь элсэрхэг, ургамал нь тачир сийрэг байдаг. Уурхайн 2021-2025 оны үйл ажиллагаа уулын хээрийн ургамалжилт бүхий бэлчээрийг хамарна. Уулын хээрийн ургамалжилтанд монгол өвс (*Stipa gobica*), таана (*Allium polyrrhizum*), хялгана, бор бударгана (*Salsola passerina*), улаан бударгана (*Reamauria soongarica*), түнтгэр баглуур (*Anabasis brevifolia*), гялгар дэрс (*Achnatherum splendens*), шар бударгана (*Kalidium foliatum*), сибирь хармаг (*Nitraria sibirica*), зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes soongarica*), хөмүүл (*Allium mongolicum*), төлөгчдүү бор таар (*Ajania nelillous*), орог тэсэг (*Eurato ceratoides*), харгана зэрэг ургамлууд зонхилон тархаж бэлчээрийн үндсэн хэв шинжийг бүрдүүлэх ба сөөг, сөөгөнцөрүүд дагалдах үүрэгтэй оролцоно.

Ургацын байдал жилүүдээр харилцан адилгүй байх бөгөөд нөлөөллийн гол хүчин зүйл нь тухайн жилийн цаг уурын үзүүлэлт, түүний дотор ургамал ургах хугацаа хур тунадасны хэмжээнээс хамаарна.

Амьтны аймаг: Ховд аймгийн Дарви сумын нутаг нь Монгол орны амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954) хойт говийн тойрог, баруун хойт монголын тойрог, баруун говийн тойргуудын нутагт багтдаг. Тухайлбал, Дарви сумын нутгийн өмнөд хэсэг нь амьтны газарзүйн хувьд баруун говийн тойрогт багтдаг. Уурхай орчмын нутгаар 6 баг, 15 овог, 31 төрөл, 43 зүйлийн хөхтөн амьтан тархсан гэх судалгааны мэдээлэл байх боловч БОННУ-ний энэхүү тайлангийн үйл ажиллагаа явуулах газар нутгаар амьтны тархац нэн бага, жижиг мэрэгчид болон туулай хэлбэртнүүд мэр сэр үзэгдэнэ.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Төслийн бүс нутагт хамгийн ойр байршилтай Мянган угалзатын байгалийн цогцолбор газар, Сутай хайрхан уулын байгалийн нөөц газар байх бөгөөд төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөхгүй болно.

Түүх, соёлын дурсгалт зүйл: Энэ төслийн нутагт хамгийн ойр орших түүх, соёлын дурсгалууд (хэрэгсүүр, шарил, чулуун хөшөө, тахилгатай газар) 3.1-14.2 км алслагдсан зайтай байна. Өөрөөр хэлбэл эдгээр түүх, соёлын жижиг дурсгалууд, тэдгээрийн хамгаалалтын бүсэд төслийн объект хамаарахгүй түүх, соёлын дурсгалууд өртөхгүй.

Нийгэм, эдийн засгийн байдал: 50 гаруй жилийн турш нүүрс олборлож байгаа тус уурхайн хувьд дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдсэн төдийгүй уурхайг түшиглэсэн үйлдвэр-бизнесийн суурин хөгжсөн байна. Үйл ажиллагаа нэгэнт тогтворжсон тул уурхайн өнөөгийн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэд, ажилгүйдэл, нийгмийн байдалд үзүүлэх нөлөө мөн тогтворжсон. Уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотой төсөвт төвлөрүүлэх мөнгөн хөрөнгө нэмэгдсээр жилд дунджаар 40.0 гаруй сая төгрөг байгаа нь эдийн засагт оруулах хамгийн том үнэлгээ болно. Дарви суманд холбооны салбар, ШТС-тай сүүлийн үед үүрэн телефоны Мобиком, Жи-Мобайл, Скайтел, Юнителийн сүлжээ өргөн нэвтэрсэн бол Хөшөөтийн уурхайд интернэтийн шилэн кабель, үүрэн телефоны 4 сүлжээг ашиглаж байна.

Ховд аймагт Баруун босоо тэнхлэгийн Булган-Бодончийн амны хатуу хучилттай зам, Бодончийн ам-Ховдын чиглэлийн замтай. Харин "МоЭнКо" ХХК-ийн хувьд Хөшөөт Булган Ярантын чиглэлд 311 км хатуу хучилттай замыг 2011 онд байгуулж ашиглалтад оруулан нүүрс тээвэр хийдэг.

ОРШИЛ

Хөшөөтийн чулуун нүүрсний орд нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд оршино.

“Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төсөл нь нийт 1885.02 га талбайг хамарсан MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299 тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрөлтэйгээр нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Хөшөөтийн чулуун нүүрсний төслийн үйл ажиллагаа нь байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, барилга, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй зэрэг нийгмийн салбарын бүхий л төрлийг хамарсан цогц хэлбэрээр явагдаж байгаа бөгөөд түүнтэй холбогдох хууль, журам, заавар, стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

Цаашид уурхайн үйл ажиллагаа өргөжих тусам байгаль орчны ажлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах ба мөн олон улсын дэвшилтэт технологийг байгаль орчныг хамгаалах ажилд нэвтрүүлэн ажиллах болно.

МоЭнКо ХХК нь 2007 оноос өрөмдлөг хайгуулын ажил эхэлсэн бөгөөд энэ үеэс эхлэн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг мэргэжлийн байгууллага болон компанийн дотоод нөөц бололцоогоор хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Хөшөөт тус нутгийн байгаль орчны суурь судалгааг “Эко Алтай” ХХК-иар 2007 онд хийлгэсэн.
- Хөшөөтийн нүүрсний уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 2009 онд “Геоценоз” ХХК, 2015 онд Гурван тайга ХХК, 2020 онд Давхар Ертөнц ХХК-иар тус бүр хийж гүйцэтгүүлсэн.
- Нүүрсний алсын тээврийн хатуу хучилттай замын БОНБНУ-г 2008 онд “Бөхөн Чингэлэг” ХХК-иар хийлгэсэн.
- Хөшөөтийн нүүрсний уурхайн дотоодын хэрэгцээг хангах Дулааны цахилгаан станцын БОНБНУ-г “Бөхөн Чингэлэг” ХХК-иар хийлгэсэн.
- Хөшөөтийн нүүрсний уурхайн БОНБНУ-г 2009 онд “Бөхөн Чингэлэг” ХХК-р хийлгэж, нэмэлт тодотголын ажлыг 2015 онд “УМСМ” ХХК, 2021 онд “ОЙТ БҮС” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн.
- 2014 онд Байгаль орчны аудитыг “Цэхи консалтинг” ХХК-иар, 2016, 2018, 2020 онуудын Байгаль орчны аудитыг “Мөнх Мизу” ХХК болон ЭБГ Консалтинг ХХК-иар хийлгэсэн.
- Бусад барилга объектуудын БОНБНУ-г “Газар Дэлхий” ХХК, “УМСМ” ХХК, “Билитон гилори” ХХК-иар тус тус хийлгэсэн.
- Хөшөөтийн уурхайн ажилтнуудын кемп болон оффисын “Цэвэрлэх байгууламжийн төсөл”-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Давхар Ертөнц ХХК-иар гүйцэтгүүлсэн.
- 2018-2022 оны хугацаанд Дарви, Цэцэг, Үенч сумдад орон нутгаас ирсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 151.2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж сум орон нутагт хүлээлгэн өгсөн байна.
- 2017-2022 оны хугацаанд Ховд Жаргалант, Дарви, Цэцэг, Үенч, Булган сумдад ногоон байгууламжыг нэмэгдүүлэх зорилгоор 41.400 ширхэг модны суулгац тарьж, хүлээлгэн өгч хамтран ажилласан байна. Ерөнхийлөгчийн санаачилсан ТЭРБУМ МОД үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд Дарви, Цэцэг, Алтай, Булган сумдад 20га талбайд 20,000 ширхэг суулгацаар ойн зурвас байгуулах ажлыг мэргэжлийн байгуулгаар гүйцэтгүүлж байна.

- 2018-2022 оны хугацаанд Дарви, Цэцэг, Үенч сумдад нийт 13 булгийн эхийг хашиж хамгаалж сум орон нутагт хүлээлгэн өгсөн байна.
- 2017, 2018 онд Дарви сумын Мөрөн багт тус тус 200га нийт 400га талбайг тариалангийн талбайн зориулалтаар хашиж хамгаалан орон нутагт хүлээлгэн өгсөн.
- 2019 онд Цэцэг сумын Хажинга багт 50га талбайг тариалангийн талбайн зориулалтаар хашиж хамгаалан орон нутагт хүлээлгэн өгсөн.
- 2019, 2021 онд Булган сум Алаг толгой баг Булган гол дагуу Минж хамгаалах зорилгоор 25га талбайг хашиж хамгаалан 2021 онд тор 6000 метр, шон 2000 ширхэг, боох төмөр утас 15 боодлыг Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаанд хүлээлгэн өгсөн.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “МоЭнКо” ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж 23, Түшиг төв, 3 давхар, Утас: (976)-7711-0567, (976)-9911-0170 Вэб хуудас: www.moenco.mn, E-mail:oyunchimeg.ja@mongolia-energy.com


Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:

- Улсын бүртгэлийн дугаар: 9019023025
- Улсын регистрийн дугаар: 5141583

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:

Хөшөөтийн нүүрсний уурхай нь (MV-015289, MV-011888, MV-011887, MV-006525, MV-004322, MV-001640, MV-001414, MV-020299) тоот ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн 1885,02 га талбайг хамран үйл ажиллагаагаа явуулдаг.

Төслийн талбайн байршил: Хөшөөтийн нүүрсний орд нь Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Ховд хотоос зүүн урагш 210 км, Дарви сумаас баруун урагш 50 км, Цэцэг сумаас хойш 29 км-ийн зайд байрладаг.



Зураг 1. Хөшөөтийн нүүрсний ордын байршлын зураг

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбай,га	Талбайн солбицлууд	
			Өргөрөг	Уртраг
1	MV-001414	28.8	93° 19' 29.56"	46° 47' 51.49"
			93° 19' 7.56"	46° 47' 51.49"
			93° 19' 7.56"	46° 48' 11.5"
			93° 19' 29.56"	46° 48' 11.5"
2	MV-001640	40.87	93° 19' 14.56"	46° 48' 21.5"
			93° 18' 49.57"	46° 48' 21.5"
			93° 18' 49.57"	46° 48' 46.49"
			93° 19' 14.56"	46° 48' 46.49"
3	MV-004322	53.97	93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 14.56"	46° 48' 11.5"
			93° 19' 14.56"	46° 48' 44.5"
			93° 19' 39.57"	46° 48' 44.5"
4	MV-006525	45.79	93° 19' 39.55"	46° 47' 31.49"
			93° 19' 14.56"	46° 47' 31.49"
			93° 19' 14.56"	46° 47' 51.49"
			93° 19' 29.56"	46° 47' 51.49"
			93° 19' 29.56"	46° 48' 11.5"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
5	MV-011887	203.48	93° 19' 7.56"	46° 48' 11.5"
			93° 19' 7.56"	46° 47' 51.49"
			93° 19' 14.56"	46° 47' 51.49"
			93° 19' 14.56"	46° 47' 31.49"
			93° 18' 9.56"	46° 47' 31.49"
			93° 18' 9.56"	46° 48' 21.5"
			93° 19' 14.56"	46° 48' 21.5"
			93° 19' 14.56"	46° 48' 11.5"
6	MV-011888	1296.31	93° 21' 59.57"	46° 50' 41.49"
			93° 21' 59.56"	46° 48' 11.5"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 39.57"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 46.49"
			93° 18' 49.57"	46° 48' 46.49"
			93° 18' 49.57"	46° 50' 41.49"
7	MV-015289	39.25	93° 19' 54.55"	46° 47' 31.49"
			93° 19' 39.55"	46° 47' 31.49"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 54.55"	46° 48' 11.5"
8	MV-020299	176.55	93° 19' 45.89"	46° 48' 51.73"
			93° 20' 21.97"	46° 48' 35.75"
			93° 20' 41.67"	46° 48' 11.5"
			93° 19' 39.55"	46° 48' 11.5"
			93° 19' 39.57"	46° 48' 64.5"
			93° 19' 14.55"	46° 48' 44.5"
			93° 19' 14.56"	46° 48' 46.49"
			93° 19' 49.57"	46° 48' 48.49"
			93° 19' 49.57"	46° 49' 17.75"
93° 19' 23.93"	46° 49' 1.78"			

Хүснэгт 2. Төслийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	Геологийн нөөц		
1.1	Бодитой нөөц (В зэргээр)	сая тн	87.9
1.2	Боломжтой нөөц (С зэргээр)	сая тн	32.2
1.3	Нийт нөөц (В+С1 зэргээр)	сая тн	120.2
2	Ил уурхай		
2.1	Уулын ашиглалтын технологи	Ил уурхайн авто тээвэртэй систем	
2.2	Үйлдвэрлэлийн нөөц	сая тн	Ч2-22.6 Ч3-18.8 Ч4-42.9 Нийт 84.4
2.2	Уурхайн ашиглалтын хугацаа	жил	25
3	Нүүрс баяжуулах үйлдвэр		
3.1	Баяжуулах технологи	Гравитаци+Флотаци	
3.2	Үйлдвэрийн ашиглалтын хугацаа	жил	23
3.3	Бүтээгдэхүүний гарц	%	65.03
3.4	Коксжих нүүрсний хэмжээ	сая тн	24.4
	Үнслэг	%	9.9
	Чийг	%	10-12
4	Дэд бүтэц		
4.1	Ус хангамжийн эх үүсвэр	Хөшөөтийн голын хөндийд орших худгууд	
4.2	Цахилгааны эх үүсвэр	Дизель генератор+ Баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ	
5	Эдийн засаг		
5.1	Баяжуулсан нүүрсний үнэ	ам.доллар	85
5.2	Борлуулалтын орлого	тэрбум төг	4672
5.3	Үйл ажиллагааны зардал	тэрбум төг	3598
5.4	1 тн нүүрсэнд ногдох баяжуулалтын зардал	төг тн	3312
5.5	1 тн баяжуулсан нүүрсний бүрэн өөрийн өртөг	мян төг тн	160.4
5.6	Цэвэр ашиг	тэрбум төг	816.7
5.7	Үйл ажиллагааны мөнгөн урсгал	тэрбум төг	810.4
5.8	Хөрөнгө оруулалт	тэрбум төг	45.4
5.9	Улс орон нутагт оруулах татвар төлбөр	тэрбум төг	492.1
Эх сурвалж: Гложекс ХХК, Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, 2017			

1.2 Ордын нөөц

2007-2014 онд Хөшөөтийн ордод “МоЭнКо” ХХК өөрийн хөрөнгөөр геологи хайгуулын ажлыг гүйцэтгэж, ордын нөөцийг 2015 оны 11-р сарын 13-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн бодитой (В) зэргээр 87,988.56 мян.тн, боломжтой (С) зэргээр 32,216.82 мян.тн, нийт 120,205.36 мян.тн нүүрсний нөөцийг Монгол улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн. Хөшөөтийн нүүрсний орд нь дээрээс доош чиглэлд D, A, A1, B, C гэсэн 5 нүүрсний давхаргаас тогтдог. Нүүрсний давхаргууд нь чулуулаг болон нүүрсний олон салаалсан үеүдтэй, нийлмэл бүтэцтэй.

Хүснэгт 3. Ордын нөөц (B+C)

Байршил	Нүүрсний давхарга	Нөөцийн зэрэглэл	Нүүрсний төрөл	Ордын нийт нөөц			
				Нийт эзлэхүүн, мян.м ³	Нүүрсний нөөц, мян.тонн	Чулуулгийн үеийг оруулсан нөөц, мян.тонн	
Хөшөөт	C	B	Ч2	8,730.87	9,830.30	13,969.39	
			Ч3	9,210.30	10,379.42	14,736.48	
			Ч4	31,646.61	36,145.76	50,634.57	
		C	Ч2	1,968.36	2,334.44	3,149.37	
			Ч3	150.50	104.20	240.80	
			Ч4	14,286.04	16,180.93	22,857.66	
					65,992.68	74,975.05	105,588.28
		B	B	Ч2	8,079.30	9,147.48	12,926.87
				Ч3	8,965.86	10,262.62	14,345.38
	Ч4			10,621.21	12,222.98	16,993.94	
	C		Ч2	1,968.17	2,231.54	3,149.08	
			Ч3	2,607.88	3,002.17	4,172.61	
			Ч4	5,652.22	6,454.79	9,043.55	
				37,894.64	43,321.57	60,631.43	
	B+C				103,887.32	118,296.62	166,219.71
	Хойд Хөшөөт	C	C	Ч2	121.91	139.61	195.05
				Ч3	205.50	231.60	328.80
				Ч4	699.21	795.86	1,118.73
				1,026.61	1,167.06	1,642.58	
B		C	Ч2	60.88	69.06	97.41	
			Ч3	451.83	516.31	722.93	
			Ч4	138.40	156.31	221.45	
				651.12	741.67	1,041.79	
B+C				1,677.73	1,908.74	2,684.37	
Хөшөөтийн ордын нийт нөөц				105,565.05	120,205.36	168,904.08	

1.3 Дэд бүтэц

Уурхайн дэд бүтцийн хангамж үндсэндээ бүрэн хангагдсан. 2014 онд нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг Улсын комисст хүлээлгэн өгч одоогоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Уурхайн барилга байгууламж

Уурхайн захиргааны барилгууд, Хүндлэл кемп, Засварын газар, Уулын оффис, Гаалийн хяналтын талбай, хуурай баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Үйлдвэрийн туслах барилга байгууламж

Хөшөөтийн нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд хяналт шинжилгээний лаборатори, үйлдвэрийн засвар механикийн хэсэг, үйлдвэрийн удирдлагын өрөө, үйлдвэрийн оффис зэргийг төлөвлөж барьсан.

Хяналт шинжилгээний лаборатори: Хөшөөтийн уурхайн лаборатори нь 2013 оны 3 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Лаборатори нь 20 гаруй төрлийн 50 орчим тоног төхөөрөмжтэй.

Үйлдвэрийн ажилчдын оффис: Энэ оффис нь баяжуулах үйлдвэрээс баруун урд зүгт үйлдвэрийн хашааны гадна талд 152 м² талбайг хамарсан 5 м-ийн өндөртэй сэндвичэн байгууламжид байрлана. Үйлдвэрийн оффис нь инженер, техникийн ажилчдын өрөө, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, сургалт, семинар, зааварчилгааны өрөөтэй. Тус үйлдвэрийн оффисыг 2015 оны 9 сарын 1-нд ашиглалтанд оруулсан.

Үйлдвэрийн засварын хэсэг: Засварын хэсэг нь нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ)-ийн тоног төхөөрөмжүүдэд урьдчилсан төлөвлөгөөний дагуу ээлжит засвар хийхийн зэрэгцээ, шинээр суурилагдах тоног төхөөрөмжийг угсрах, аваарын үед шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн засвар, гагнуурын болон бусад ажлыг гүйцэтгэнэ.

Үйлдвэрийн удирдлагын өрөө: Орчин үеийн удирдах систем нь НБҮ-ийг удирдлага болон хяналтаар хангаж ажилладаг. Үйлдвэрийн удирдлагын өрөө нь НБҮ-ийн зүүн хойд талд байрлана. НБҮ нь автомат, хагас автомат, механик ажиллагаатай бөгөөд удирдлагын өрөөнд 3 камер, үйлдвэрийн хэсэгт 5 камерыг суурилуулсан.

Операторын хяналт нь үйлдвэрийн удирдлагын өрөөнд байрлах бөгөөд хяналтын системийн дэлгэцүүд нь үйлдвэрийн үе шат процесстой логик хамааралтай, дараалал бүхий хөдөлгөөнт дүрс, зураг болон хүснэгтэн мэдээллүүдийг агуулна. Эдгээр дэлгэцүүд нь тоног төхөөрөмжүүдийг удирдах, тэдгээрийн төлөв байдлыг хянахад хялбар бөгөөд, өргөн боломжийг олгоно. Мөн уг систем нь мэдээллийг хадгалж архивлах, төрөл бүрээр тайлан гаргах болон алдааны мэдэгдэл харуулах боломжтой. Системийн хүчин чадал найдвартай ажиллагаа нь сүлжээний төхөөрөмжүүдийн зөв сонголт, суурилуулалт кабелийн ажил болон тоног төхөөрөмжийн хамгаалалт найдвартай тэжээлийн эх үүсвэрээр хангагдсан.

Ус хангамж

Гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд 2007 онд Хөшөөтийн уурхайгаас 50 км радиустай талбайн хэмжээнд геофизикийн судалгаа явуулан, газрын доорх устай 5 талбайг ялган, 2015 онд Боорчийн голын адгийн хөндий болон Хөшөөтийн голын хөндийд тус тус ашиглалтын нөөцийг батлуулсан. Хөшөөтийн голын хөндийд 2008, 2011 онуудад өрөмдсөн 3 цооногт шавхалт туршилтын ажлыг гүйцэтгэн газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлж 18.5 л/с буюу 1598.4 м³/хоноогоор БОНХЯамны Усны нөөцийн зөвлөлийн 2013 оны 10-р сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан. Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэлийн болон унд, ахуйн усны хэрэглээг усан орчинд үзүүлэх нөлөө, үнэлгээний хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Хөшөөтийн уурхайн усан хангамжийг Хөшөөт голын хөндийд байрлах Well 2 худаг болон Хөндлөнгийн хагарлын дагуу өрөмдсөн шүрүүлэн шавхах зориулалттай WDH-028 WDH-03 худгуудаас хангадаг.

Боорчийн голын адгийн хөндийн талбай нь уурхайгаас 45-60 км зайд орших ба газрын доорх усны урьдчилсан болон нарийвчилсан судалгааны ажил хийгдсэн. Энэ ажлаар Боорчийн голын адгийн хөндийн талбайн газрын доорх усыг үйлдвэрлэлийн C1 зэргээр 18765 м³/хоног буюу 217.2 л/сек ашиглалтын нөөцийг БОНХЯамны сайдын 2009 оны 12-р сарын 07-ны өдрийн 377 дугаар тушаалаар батлуулсан. Одоогоор энэ талбайгаас ус ашиглаагүй байна.

Ариун цэврийн байгууламж

“Хүндлэл” кемп нь 50-300 хүний бохир ус цэвэрлэх байгууламжтай. Бохир ус цэвэрлэх байгууламж нь байгаль орчинд ямар нэгэн хор нөлөөгүй.

Ахуйн бохир усыг урсгахгүйгээр цооногтоо боловсруулах боломжтой ус цэвэршүүлэх төхөөрөмж юм. Цэвэрлэх байгууламж руу урсаж орсон бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрсний боловсруулах төхөөрөмж рүү илгээгдэж хөрсний бичил биетээр хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулна. Тус байгууламжийг цахилгаангүй газарт суурилуулах боломжтой. Байгалийн шалгарсан цэвэршүүлэх чадварыг бүрэн ашигладаг систем учраас ердийн ажиллагааны аргатай харьцуулахад засвар үйлчилгээний зардал болон ажиллагааны ачаалал багатай. Цэвэрлэх процесст ашиглагддаг нэвчүүлэн цэвэршүүлэх материалтай хатуу хаалт болон ус нэвтрүүлдэггүй хучилгат бокс зэрэг хөрсний даралтанд нилээд уян хатан шинж чанартай бат бөх болно. Мөн хүчиллэг, шүлтлэг шинж чанарт тэсвэртэй бөгөөд зэврэлтээс хамгаалах шинж чанартай тул байнгын хэрэглээ болгох боломжтой.

Тус байгууламж нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

- ✓ Анхны ялган боловсруулах хэсэг
- ✓ 2-р ялган боловсруулах хэсэг
- ✓ Шүүх хэсэг

Ялган боловсруулах танкны систем нь хөрсний байгалийн цэвэршүүлэх чадварыг дээд зэргээр ашигладаг ус дахин ашиглах боломжтойгоор цэвэршүүлэх систем юм. Ялган боловсруулах төхөөрөмжид оруулсан бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрс боловсруулах төхөөрөмж рүү илгээх бөгөөд хөрсний бичил биетээр хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулдаг.

Цахилгаан хангамж

Хөшөөтийн нүүрсний уурхайг 16 ширхэг дизель генератор болон Баруун бүсийн ЦДАШ-аас хангаж байна. Баруун бүсийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангахын тулд 110/35/10 кВ-ын "Манхан" дэд станцын 110 кВ-ын хуваарилах байгууламжийг өргөтгөж төслийн талбай хүртэл 35 кВ-ын шугам татсан.

Зам, харилцаа холбоо

"МоЭнКо" ХХК-ийн хувьд Хөшөөт-Булган Ярантын чиглэлд 311 км хатуу хучилттай замыг 2011 онд байгуулж ашиглалтанд оруулсан.

Уурхайн тосгонд Мобиком, Скайтел, Юнител болон Жи-Мобайлын сүлжээг ашигладаг ба ил уурхайд богино долгионы радио холбоо ашиглаж байна. Уурхайн оффис Мобикомын сүлжээг ашиглан интернэтэд холбогддог, уурхайн тосгонд сансарын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авдаг.

Дулаан хангамж

Өвлийн улиралд барилга, байгууламжийг нүүрсээр галладаг усан халаалтын зуухаар халаадаг. Нүүрс баяжуулах үйлдвэр болон бусад туслах нэгжүүдийг уурын зуухыг үйлдвэрлэлийн талбайд байрлуулж, үйлдвэрийн барилга байгууламжийн дулаан хангах эх үүсвэр болгон ашиглана. Уурын зууханд шаардлагатай нүүрсийг баяжуулах үйлдвэрээс гарах эрчим хүчний нүүрсээр хангана.

1.4 Нүүрс олборлолт, ил уурхайн хүчин чадал

“Хөшөөт”-ийн ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-д тусгаснаар ил уурхайн олборлолтын хүчин чадал эхний жилд 1.6 сая.тн, хоёр дахь жилд 2.6 сая.тн, 3 дахь жилээс 3-4 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн. Дээрх хүчин чадлаар ил уурхай нийт 25 жил ажиллана.

Ил уурхайгаас олборлох Ч2, Ч3, Ч4 ангиллын нийт 84.4 сая.тн үйлдвэрлэлийн нөөцийн нүүрсийг баяжуулах үйлдвэрт тэжээж “Хүнд орчны циклон + TBS сепаратор + Флотаци” -ийн

технологиор баяжуулана. Баяжуулсан коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс, нунтаг нүүрс гэсэн 3 бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Ордын уул-геологийн нөхцөлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор автотээвэртэй ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

1.5 Нүүрс баяжуулах технологи, тоног төхөөрөмж


Хөшөөтийн чулуун нүүрсний уурхай нь нүүрсийг механик бохирдлоос ангилан ялгах хуурай баяжуулах технологитой. Хөшөөтийн нүүрс баяжуулах үйлдвэр нь бэлтгэх хэсэг, ангилан баяжуулах хэсэг, гаалийн хяналтын гүний бүс гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Нүүрс баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал: 2.8 сая. тн/жил (дундажаар) хоногт 2 ээлжээр, ээлжиндээ 11 цагаар ажилладаг.

Баяжуулах үйлдвэрт ил уурхайгаас ирсэн түүхий нүүрсийг үл хөдлөх шигшүүрийн тусламжтайгаар шигшинэ. 500 мм-ээс доошхи ширхэглэлтэй нүүрс хүлээн авах бункерээр дамжин гинжит конвейрээр тээвэрлэгдэн шүдтэй давхар булт бутлуур руу орно. Нүүрс бэлтгэх ажлыг зогсолтгүй байлгах үүднээс нүүрс хүлээн авах бункерийн ойролцоо талбайд нүүрс хүлээн авах тэжээлийн талбай 2-ийг байгуулсан. Түүхий нүүрс хүлээн авах тэжээлийн талбай дээр утгуурт ачигчийг ашигладаг.

Бутлуураас 0-80 мм ширхэглэлтэй болтол бутлагдана. Бутлагдсан нүүрс туузан конвейрээр тээвэрлэгдэн хуурай ангилах төхөрөмж рүү ачаалагдана. Хуурай ангилах төхөрөмжөөс коксжих нүүрс болон хаягдал гэсэн 2 бүтээгдэхүүн гарна.

Нүүрс баяжуулах тоног төхөөрөмж

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөрөмжийг технологийн туршилтын үр дүн, үйлдвэрийн түүхий эдийн нөөц, тоног төхөрөмжийн хүчин чадал, өртөг зардал, ашигт ажиллагааны түвшин, сэлбэг хэрэгслийн олдоц, бүс нутгийн дэд бүтэц гэх мэт хүчин зүйлүүдийг үндэслэн сонгосон. Засвар үйлчилгээ, сэлбэг материалын хангалт, нүүрс баяжуулах технологи ажиллагааг тасралтгүй найдвартай байлгах үүднээс тоног төхөрөмжүүдийг нэг брэндийн ижил төрлийн тоног төхөрөмжүүд байх нь давуу талтай гэж үзэн багц төхөрөмжийн сонголтыг хийсэн байна.



Зураг 2. Тоног төхөөрөмжийн холболтын бүдүүвч

1. Үл хөдлөх шигүүр, 2. Хүлээн авах бункер, 3. Гинжит тэжээгүүр, 4. Булт бутлуур, 5. Бутлагдсан нүүрсний туузан конвейер, 6. Хуурай ангилах багц төхөрөмж, 7. Бүтээгдэхүүний туузан конвейер, 8. Завсрын бүтээгдэхүүний туузан конвейер, 9. Хаягдлын туузан конвейер, 10. Төхөрөмжийн хуваарилах конвейер

1.6 Өрөмдлөг, тэсэлгээний ажил

Хөшөөтийн ордын хөрсний дээд хэсэг нь суларч өгөршсөн байдаг ба үндсэн чулуулаг нь элсжин, элсэрхэг шаваржин, шаваржингаас голлон бүрддэг. Өгөршлийн бүсийн зузаан 3 м. Хөрсний ихэнх нь үндсэн чулуулаг бөгөөд гуу жалга хэсгээр дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дүүргэгч байдлаар хучдаг. Үндсэн чулуулгууд нь ихэвчлэн салаавчилсан тогтоцтой байдаг.

Тус ордын чулуулгийн физик-механикийн шинж чанар, уурхайн жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ зэргийг үндэслэн дунд зэргийн хатуулагтай чулуулаг өрөмдөх зориулалт бүхий өрмийн машин ажиллуулах нь тохиромжтой.

Хөрсний чулуулгийн нэг тэсэлгээний блокын өндөр 10 м, өргөн 12.5 м байна. Нэг удаагийн тэсэлгээний блокын эзлэхүүн төслийн техникийн даалгаврын дагуу 3 үе шаттайгаар өөрчлөгдөн нэмэгдэх тул ашиглалтын жилүүдэд өөр өөр хэмжээтэйгээр тогтоогдсон. Уурхай жилд нийт 653.47 мян.у.м өрөмдөж 5,605.33 тн тэсрэх бодис хэрэглэнэ. Тэсэлж бэлтгэсэн уулын цулын нормоор экскаваторын ажлыг 7-14 хоногийн бэлэн нөөцтэй байхаар тооцож уулын ажлыг зохион байгуулдаг. Жилд 355 хоног тэсэлгээ хийх ба тэсэлгээний мөчлөг 7 хоногт 1 удаа байна.

1.7 Уурхайн тээвэр

Уурхайн ашиглалтын технологийн дагуу гаргасан уулын цулыг тээвэрлэх ажлыг экскаватор-автомашинны хослолоор сонгогдсон тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ. Календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан хуулах хөрсийг гадаад овоолгод, олборлосон нүүрсийг уурхайн мөргөцгөөс баяжуулах үйлдвэр хүртэл дотоод технологийн тээврээр гүйцэтгэнэ.


1.8 Ил уурхайн үндсэн хэмжээс, загварчлал

Ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг одоогийн ашиглагдаж буй уурхайн хэмжээсүүдэд үндэслэн ажлын доголын өндрийг 5 м, ажлын бус доголын өндрийг 10 м, уурхайн хажуугийн ерөнхий өнцгийг 35-36°-аар тус тус тооцжээ. Ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	5
2	Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	10
3	Ажлын доголын хажуугийн өнцөг	град	65
4	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	65
5	Ажлын талбайн өргөн	м	42.4
6	Траншейн налуу	% ₀	100
7	Доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	21.5
8	Замын өргөн	м	23
9	Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг	град	35-36

Ил уурхайн төлөвлөлтөөр ашиглалтын эцсийн үед уурхай нь 07-46-р хайгуулын шугамын хооронд 2626 м урттай, 925 м өргөнтэй, нийт 242.9 га талбайг хамарна. Газрын гадаргуугаас 1830 м-ийн түвшин хүртэл дунджаар 250 м гүнтэй уурхай үүснэ. Уурхайн эцсийн байдлын зургийг дараах хэсэгт үзүүлэв.



Зураг 3. Ил уурхайн ашиглалтын эцсийн байдал

1.9 Усан хангамж

МУ-ийн Усны тухай хуулийн дагуу Монгол улсын ЗГ -н хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2022.06.20 өдрийн 141 тоот Ус ашиглах дүгнэлт, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2022.07.06 өдрийн А/09 тоот Ус ашиглах зөвшөөрөл, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2022.07.06 өдрийн №01/2022 тоот Ус ашиглах гэрээ, Ховд аймгийн БОГазрын 2020.07.08 өдрийн 2020/01 дугаар Ус ашиглах эрхийн бичиг (2023.08.11-г хүртэл 1 жилээр сунгалт хийгдсэн) зэрэг баримт бичгийг дээрх хуулийн хүрээнд бүрдүүлж ажиллаж байна.

Хөшөөтийн уурхайн ус ашиглалтын төлбөрийг Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2022.07.06 өдрийн Ус ашиглах гэрээний дагуу Худгийн тоолуурын заалтыг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн дансанд төлбөр төлдөг.

Хөшөөтийн уурхайн Хөрс хуулалтын ажил гүйцэтгэж буй “Моннис” ХХК, “Алтайн зам” ХК-иуд, нүүрс олборлолтын ажил гүйцэтгэж буй “Мезом” ХХК, “Алтайн зам” ХК-иуд болон бусад гэрээт компаниудтай хамтран ажиллаж байна.

Хөшөөтийн уурхайн унд-ахуйн ус, үйлдвэрлэлийн усны хэрэглээг нэг эх үүсвэрээс 2 тоолуур ашиглана ялгаж хэмжиж байгаа.



Зураг 4. Well-2 худаг, суурилуулсан усны тоолуур



Зураг 5. WDH-03 шавхалтын худаг, суурилуулсан усны тоолуур

Хөшөөтийн голын хөндийд өрөмдсөн цооног болон булгын усны химийн шинжилгээг 2012 оноос хойш тасралтгүй сард 1 удаа Шинжлэх ухааны академи Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны лабораторид шинжилгээ хийлгэж ирсэн ба бүх үзүүлэлт нь ундны усны стандарт хангаж хүний унданд хэрэглэхэд тохиромжтой гэж тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.

Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь “ундны усны стандарт /MNS 900:2005/-ын шаардлага хангаж байгаа учир хүний унданд хэрэглэхэд тохиромжтой” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

2022 онд Бактерлоги, ерөнхий хими, Хүнд металь зэрэг шинжилгээг газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн усны лаборатори, ХАБҮЛЛ лаборатори, МОНГОЛ-УС ТӨҮГ өгсөн ба шинжилгээний үр дүнг хавсаргав.

Мөн ус ашиглалтыг зориулалтаар нь хянах зорилгоор Well-2 дугаартай худагт STD-815 АНД маркын гадна камер болон STD-791 АНД маркын дотор камерыг суурилуулсан. Худагт камер суурилуулсанаар үйлдвэрлэлийн болон унд-ахуйн усны хэрэглээг зориулалтын машинд ачиж байгаа эсэхийг хянаж, ус ашиглалтын журналтай тулгаж баталгаажуулж байгаа болно. Мөн Хүйсийн Говь-Цэцэг нуурын сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглалтын гэрээнд тусгасаны дагуу ус ашиглалтын хяналтын камерыг суурьлуулсан болно.



Зураг 6. Худагт суурилуулсан ус ашиглалтын хяналтын камер

Хяналтын камер суурилуулахаас гадна цэвэр ус зөөвөрлөж буй машиныг тэмдэгжүүлж зориулалтаар нь ялгасан болно.



Зураг 7. Ус зөөвөрлөх машиныг зориулалтаар нь ялгасан байдал

1.10 Ашигласан усны хэмжээ

Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаа 2022 онд Хөрс хуулалт хийх гэрээт компани болох Моннис ХХК, “Алтайн зам” ХК-иуд, нүүрс олборлолтын гэрээт компани болох Алтайн зам ХК, мөн Мезом ХХК, бусад гэрээт компаниудтай хамтран ажиллаж байна. Хөшөөтийн уурхайн унд-ахуйн ус, үйлдвэрлэлийн усны хэрэглээг нэг эх үүсвэрээс 2 тоолуураар авч ашиглаж байна.

Хөшөөтийн уурхайд 2022 оны 9-р сарын эцсийн байдлаар хамгийн их хүн ажилласан нь 8 сард буюу 1897 хүн, сард дунджаар 1606 хүн ажилласан байгаа юм. Тухайн жилийн ажиллах хүчийг ашигласан унд-ахуйн усны хэмжээтэй харьцуулахад 1 хүн дунджаар 28.0л усыг хоногт хэрэглэсэн тооцоо байна.

Хүснэгт 5. Унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг тооцсон байдал)

Month/Date - Огноо	2022											
	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov
Нийт хүний тоо		382	398	400	404	427	434	439	451	456		
Сарын хэрэглээ, м3/сар		1,143	1,228	1,498	1,242	1,436	1,365	1,352	1,293	1,446	-	-
Хоногийн хэрэглээ, м3/ хоног		37	42	48	41	46	46	44	42	48	-	-
Нэг хүний хэрэглээ, л/хоног*хүн		97	106	121	102	108	105	99	92	106	#DIV/0!	#DIV/0!

2022.01 сараас эхлэн 2022.10 сар хүртэлх 9 сарын унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг тооцсон байдал)

График 1. Хөшөөтийн уурхайн 2022 онд ашигласан гүний усны хэмжээ





График 2. Хөшөөтийн уурхайн 2022 онд шүүрлийн усыг шавхан зайлуулсан хэмжээ



Хүснэгт 6. Хөшөөтийн уурхайн 2022 оны жилийн ашигласан усны хэмжээ, 09 дугаар сарын 30 -ны байдлаар

2022 оны Хөшөөтийн уурхайн газрын доорх усны хэрэглээ																	
№	Огноо	Унд, ахуйн ус	МоЭнКо ХХК-ийн Үйлдвэрлэлийн ус				Моннис компанийн Үйлдвэрлэлийн ус	Алтайн зам компанийн Үйлдвэрлэлийн ус	Мезом компанийн Үйлдвэрлэлийн ус	Унд, ахуйн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Үйлдвэрлэлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Сарын ундны усны нийт хэрэглээ, м3	Сарын үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ, м3	Сарын нийт хэрэглээ, м3	Ундны усны Тоолуурын сүүлийн заагт	Үйлдвэрлэлийн усны тоолуурын сүүлийн заагт	Ашиглаж буй цооногийн дугаар
			Зам талбайн тоосжилт, бусад	Онцгой байдал, гал	Ногоон байгууламж	Эрэл хайгуул өрөмдлөг											
1	2022.1.31	1,143.00	110.00				2.00		36.87	3.61	1,143.00	112.00	1,255.00	36599	213530	Well-2	
2	2022.2.28	1,227.00	262.00	-			41.00		42.31	9.77	1,227.00	303.00	1,530.00	37827	213841	Well-2	
3	2022.3.31	1,498.00	2,052.00	10.00			3,596.00	1,351.00	48.32	226.10	1,498.00	7,009.00	8,507.00	39325	220850	Well-2	
4	2022.4.30	1,242.00	1,622.00			48.00	6,244.00	2,489.00	41.40	335.58	1,242.00	10,403.00	11,645.00	40567	231253	Well-2	
5	2022.5.31	1,436.00	3,707.00	22.00		54.00	106.00	8,702.00	46.32	556.65	1,436.00	17,256.00	18,692.00	42003	248509	Well-2	
6	2022.6.30	1,365.00	4,847.00	26.00		51.00		10,296.00	45.50	662.26	1,365.00	20,530.00	21,895.00	43368	269039	Well-2	
7	2022.7.31	1,352.00	2,969.00	22.00		184.00		6,255.00	43.61	393.55	1,352.00	12,200.00	13,552.00	44720	281239	Well-2	
8	2022.8.31	1,293.00	3,916.00	13.00	50.00	18.00		6,833.00	41.71	415.94	1,293.00	12,894.00	14,187.00	46013	294133	Well-2	
9	2022.9.30	1,446.00	4,107.00	28.00	38.00	44.00		9,773.00	48.20	509.39	1,446.00	15,791.00	17,237.00	47459	309924	Well-2	
10	2022.10.31								-	-	-	-	-			Well-2	
11	2022.11.30								-	-	-	-	-			Well-2	
12	2022.12.31								-	-	-	-	-			Well-2	
	Нийт хэрэглээ	12,002.00	23,592.00	121.00	88.00	351.00	154.00	51,742.00	20,450.00	394.25	3,112.84	12,002.00	96,498.00	108,500.00			

Хүснэгт 7. Хөшөөтийн уурхайн 2022 оны жилийн ашигласан шүүрлийн усны хэмжээ, 09 дугаар сарын 30 –ны байдлаар

2022 оны Хөшөөтийн уурхайн шүүрлийн усны хэрэглээ											
№		МоЭнКо ХХК-ийн шүүрлийн усны хэрэглээ	Мезом компанийн шүүрлийн усны хэрэглээ	Алтайн зам компанийн шүүрлийн усны хэрэглээ	Моннис компанийн шүүрлийн усны хэрэглээ	Сарын нийт хэрэглээ, м3	МоЭнКо ХХК-ийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Мезом компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Алтайн зам компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Моннис компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Ус авч буй PIT
1	2022.1.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
2	2022.2.28					-	-	-	-	-	PIT-1, RL2007
3	2022.3.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
4	2022.4.30					-	-	-	-	-	PIT-1, RL2007
5	2022.5.31	17,127.00	138.00	504.00	121.00	17,890.00	552.48	4.45	16.26	3.90	PIT-1, RL2007
6	2022.6.30	183.00				183.00	6.10	-	-	-	PIT-1, RL2007
7	2022.7.31	384.00	1,731.00	3,712.00		5,827.00	12.39	55.84	119.74	-	PIT-1, RL2007
8	2022.8.31	8,872.00	3,009.00	3,308.00		15,189.00	286.19	97.06	106.71	-	PIT-1, RL2007
9	2022.9.30	1,721.00	4,546.00	435.00		6,702.00	57.37	151.53	14.50	-	PIT-1, RL2007
10	2022.10.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
11	2022.11.30					-	-	-	-	-	PIT-1, RL2007
12	2022.12.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
	Нийт хэрэглээ	28,287.00	9,424.00	7,959.00	121.00	45,791.00					

Хөшөөтийн уурхайн ус ашиглалтын төлбөрийг ус ашиглах гэрээний дагуу худгийн тоолуурын заалт болон шүүрлийн ус ашигласан бүртгэлийг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн дансанд төлж байгаа болно. Үүнд гэрээт компаниудын ус ашигласаны төлбөр орно.

2022 оны 10 сарын байдлаар доорх унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар

Үүнд:

- Унд ахуй – 12,002 шоо метр ус
- Зам талбайн тоосжилт – 23,592 шоо метр ус
- Мод, ногоон байгууламжийн усалгаа – 88.0 шоо метр ус
- Болзошгүй галын аюулын сургалтанд ашиглаж буй хэрэглээ – 121.0 шоо метр
- Өрөмдлөгийн ажил – 351.0 шоо метр ус
- Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл – 45,791.0 шоо метр ус

2022 онд МоЭнКо ХХК Хөшөөтийн уурхайн болон Үенчийн гаалийн хяналтын талбайн ус ашигласаны төлбөрт нийт 49,758,403.31 төгрөгийг Ховд аймгийн төрийн санд төлсөн байна.

1.11 Ажиллах хүчний тухай мэдээлэл

Хөшөөтийн уурхайн хүрээнд 2022 оны 10 сарын 14-ны байдлаар нийтдээ 2311 ажиллагсад байгаа бөгөөд дараах компанийн ажилтнууд ажиллаж байна. Үүнд:

Хөшөөт төсөл ажиллах хүчний мэдээлэл		
№	Байгууллагын нэр	Ажилтнуудын тоо
1	МоЭнКо ХХК Хөшөөтийн уурхай	456
2	МоЭнКо ХХК УБ оффис	28
3	Эм И Си Транс	55
МоЭнКо ХХК-ийн туслан гүйцэтгэгч байгууллагууд		
1	ИмпериаЛ секюрити ХХК	72
2	Монруд ХХК	82
3	Эммед Партнер ХХК	12
4	Алтайн Зам ХК	618
5	Мезом ХХК	183
6	Нүүрс тээвэр 25 компани	805
Төслийн нийт ажиллах хүч		2311

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэл	Экспортын нүүрс тээвэрлэлтийн зам дагуу үүсэх тоосжилт, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж нүүрс тээврийн машины чиргүүлийг бүтээлэгтэй байхад хяналт тавих	Нүүрс тээврийн 311км зам дагуу	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол хэрэгжүүлж байна	Нүүрс ачилтын талбайгаас экспортын нүүрс ачсан шалаанз машин нүүрс пүүлэх хэсгээр дамжиж хучлагын талбайд зогсон чиргүүлээ зориулалтын хучлагаар хучуулж гаалийн байцаагчийн лац тавиулсны дараа экспортын тээвэрлэлтэд гарч байна. Чиргүүлийн хучлагын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж урагдсан, шаардлага хангахгүй хучлагыг солиулж хяналт тавьж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.1 дүгээр бүлгээс харна уу.	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2007 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
2		Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн замын усалгааг тогтмол хийх	Уурхайн талбай	4,439,071	Тогтмол хэрэгжүүлж байна	Уурхайн дотоод тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр болдог бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг. Уурхайн технологийн зам усалгааг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын нийт 6 усны машинаар дулааны улиралд өдөр бүр тогтмол, хүйтний улиралд шаардлагатай тохиолдолд хийж байна. 2022 оны 09 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 23,592.0 шоо метр ус зарцуулсан байна. (1 шоо метр усыг ашигласаны төлбөр 188,16 төгрөг) Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.1 дүгээр бүлгээс харна уу.	Агаарын тухай хууль, MNS 4585:2016
3		Нүүрс тээврийн зам болон уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэхэд хяналт тавих, (хурдны хязгаар, замын тэмдэг тэмдэглэгээ нэмэгдүүлэх нүүрс тээврийн 311 км зам дагуу)	Уурхайн талбай	1,540,000	Тогтмол хэрэгжүүлж байна	Нүүрс тээврийн зам дагуу шаардлагатай газруудад хурдны хязгаарыг мөрдүүлэх үүднээс 20, 30, 40, 60 км/ц тэмдгүүд, хурд сааруулагч байрлуулсан. Нүүрс тээврийн машинуудын хурдыг хянах үүднээс АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 маркын хурд хэмжигч багаж ашиглан хурд хэтрүүлсэн жолооч оператор нарт зөрчил, арга хэмжээ авч ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.1 дүгээр бүлгээс харна уу.	Агаарын тухай хууль, MNS 4585:2016

4		Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах	Төслийн хөнгөн тэрэгнүүд	1,408,000	Тогтмол хэрэгжүүлж байна	Хөшөөт төсөл дээр ажиллаж байгаа техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн засвар үйлчилгээний баг бүрэлдэхүүн тогтмол хянаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Өдөр бүрийн ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг ✓ Улиралд нэг удаагийн үзлэг ✓ Авто тээврийн улсын үзлэг Тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх хяналт, хэмжилийн ажлын хүрээнд МоЭнКо ХХК-ийн 55 автотээврийн хэрэгсэлийг автотээврийн хяналтын улсын үзлэг оношилгоонд орж тээврийн хэрэгсэлийн хорт утааны хэмжээ стандарт нийцэж хэвийн гарсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.1 дүгээр бүлгээс харна уу.	Агаарын тухай хууль, АБТТ Хууль
5	Гадаргын болон газрын доорхи усны нөөц	Уурхайн шүүрлийн усыг шинжилгээнд өгч, технологийн замын тоосжилтыг дарах зорилгоор зам усалгаанд ашиглах	Уурхайн талбайн	29,079,117	Тогтмол хэрэгжүүлж байна	Уурхайн шүүрлийн усны дээжийг 2, 3 дугаар улиралд Газаргүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны лаборатори, “Монгол-Ус” ТӨҮГ, МХЕГ-н Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид ерөнхий хими, хүнд металлын шинжилгээнд хамруулж технологийн зам усалгаанд ашиглаж байна. 2022 оны 09 сарын 30-ний өдрийн байдлаар Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл – 45,791.0 шоо метр ус шавхан ашигласан байна. (1 шоо метр усыг шавхан зайлуулах төлбөр 635,04 төгрөг) Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.2 дугаар бүлгээс харна уу.	Усны тухай хууль
6		Бусад ус ашиглалтын төлбөр болон хэмжээ	Уурхайн талбай болон Үенчийн гаалийн хяналтын бүс	16,240,216		Унд ахуй – 12,002 шоо метр ус Мод, ногоон байгууламжийн усалгаа – 88.0 шоо метр ус Болзошгүй галын аюулын сургалтанд ашиглаж буй хэрэглээ – 121.0 шоо метр Өрөмдлөгийн ажил – 351.0 шоо метр ус Бусад үйлдвэрлэлийн зориулалттай ус	Усны тухай хууль

7	Гадаргын болон газрын доорхи усны нөөц	Хөшөөт гол, Түвшин буйр, Тахилтын булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах	Төслийн талбай орчмын уст цэгүүд	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	Уурхай орчмын уст цэгүүд болох Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булаг ойр орчмын хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.2 дугаар бүлгээс харна уу.	Усны тухай хууль
8		Засварын цехүүдэд аюултай хог хаягдлын түр хадгалах цэг байгуулах	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Нэг удаа	Засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос маслыг түр хадгалах 20 тонн багтаамжтай 2 ширхэг ёмкосыг тусгайлан засаж цементелсэн талбайд байрлуулж хаягдал тосыг хуримтлуулан хадгалж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.3 дугаар бүлгээс харна уу.	
9	Хөрсөн бүрхэвч	Түлш шатах, тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Асгаралтаас хамгаалах иж бүрдлийг шаардлагатай газруудад байрлуулан асгаралт үүссэн тохиолдолд ашиглаж байна. Мөн хөрсний бохирдолыг саармагжуулах, цэвэршүүлэх зорилгоор “Ашигтай бичил биетний био бэлдмэл ЕМ-1” ашиглаж байна. Дээрх бодисыг засварын газар, түлш түгээх цэг, генераторуудын орчимд ашиглаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.3 дугаар бүлгээс харна уу.	Байгаль орчны аудитын үл нийцэл Байгаль орчны аудитын үл нийцэл
10		Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих (шинээр хөрс хуулах бүрт)	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Шинээр хөрс хуулах тохиолдол бүрт	Тус онд шинэ засварын газар байгуулах 14 га 8,200,4м3 шимт хөрс хуулсан. Одоогоор уурхайн шимт хөрсний овоолгод 56,649.2 м3 67,979.04 тонн шимт хөрс хадгалагдаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.3 дугаар бүлгээс харна уу.	
11	Газрын хэвлий	Олборлолт, уурхайн дагалдах хийц, дотоод тээврийн зам зэрэг газар эвдрэх уурхайн ашиглалтын нөлөөгөөр шинээр эвдрэлд орсон газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Уурхайн талбай болон ажилчдын тосгон орчимд	Үйл ажиллагааны зардлаас	Тохиолдол бүрт	Шинээр эвдрэлд орсон нөхөн сэргээлт хийгдэх талбай одоогоор байхгүй.	MNS 5915:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн
12	Амьтны аймаг	Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан	Мянган угалзатын	3,870,000	Нэг удаа	Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтарч тусгай хамгаалалттай газар нутгийн	Байгаль орчныг хамгаалах тухай

		амьтанд биотехникийн арга хэмжээг авах	нурууны УТХГ			аргаль, янгир нутагладаг газрууд Цахир хамар, Яргайтын хад, Хархөтөл гэх газруудад 200 пресс өвс, 1 тонн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.4 дүгээр бүлгээс харна уу.	хууль, Амьтны тухай хууль
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг				56,576,404			

НҮҮРС ХУУРАЙ АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хуурай баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын ачиж буулгах талбайд тоосжилт бий болох	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбайд үүсэх тоосжилт бий болохоос сэргийлж тоос дарагч мананжуулагч машиныг үргэлжлүүлэн ашиглах	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Хуурай баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбайн ачилтын талбайгаас үүсэх тоосны хэмжээг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах үүднээс 4 мананжуулагч машинаар мананжуулах усалгаа хийж байна. Мананжуулагч машин нь агаарт дэгдэх тоос руу усыг мананцар болгон өндөр даралтаар цацснаар барьцалдуулан газарт буулгадаг ач холбогдолтой. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.5 дугаар бүлгээс харна уу.	БОХТ Хууль
2		Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах үйл ажиллагаанаас үүсэх нүүрсний нарийн ширхэгт тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор мананжуулагч машинаар усалгаа хийх	Нүүрс ачиж, буулгах талбай		Тогтмол		БОХТ Хууль
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг				Үйл ажиллагааны зардлаас			

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

1. Экспортын нүүрс тээвэрлэлтийн зам дагуу үүсэх тоосжилт, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж нүүрс тээврийн машины чиргүүлийг бүтээлэгтэй байхад хяналт тавих

Нүүрс ачилтын талбайгаас экспортын нүүрс ачсан шалаанз машин нүүрс пүүлэх хэсгээр дамжиж хучлагын талбайд зогсон чиргүүлээ зориулалтын хучлагаар хучуулж гаалийн байцаагчийн лац тавиулсны дараа экспортын тээвэрлэлтэд гарч байна. Чиргүүлийн хучлагын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж урагдсан, шаардлага хангахгүй хучлагыг солиулж хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 8. Нүүрс тээврийн машины хучлагын хэсгийн ажиллагаа

2. Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн замын усалгааг тогтмол хийх

Уурхайн дотоод тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр болдог бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг. Уурхайн технологийн зам усалгааг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын нийт 6 усны машинаар дулааны улиралд өдөр бүр тогтмол, хүйтний улиралд шаардлагатай тохиолдолд хийж байна. 2022 оны 09 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 23,592.0 шоо метр ус зарцуулсан байна.



Зураг 9. Уурхайн технологийн зам усалгаа

3. Уурхайн замаас үүсэх тоосжилтыг бууруулах хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэхэд хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах (хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ)

Нүүрс тээврийн зам дагуу шаардлагатай газруудад хурдны хязгаарыг мөрдүүлэх үүднээс 20, 30, 40, 60 км/ц тэмдгүүд, хурд сааруулагч байрлуулсан. Нүүрс тээврийн машинуудын хурдыг хянах үүднээс АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 маркын хурд хэмжигч багаж ашиглан хурд хэтрүүлсэн жолооч оператор нарт зөрчил, арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг 10. АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 багажаар хурд хэмжигч багаж

4. Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах

Хөшөөт төсөл дээр ажиллаж байгаа техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн засвар үйлчилгээний баг бүрэлдэхүүн тогтмол хянаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. Үүнд:

- Өдөр бүрийн ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг
- Улиралд нэг удаагийн үзлэг
- Авто тээврийн улсын үзлэг

2022 оны автотээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэг оношилгоонд МоЭнКо ХХК-ийн 55 автотээврийн хэрэгсэл үзлэгт оруулж тэнцсэн.





Зураг 11. Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ

2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц

1. Уурхайн 1-р амнаас шүүрэх шүүрлийн усыг шинжилгээнд өгч, уг усыг технологийн хэрэгцээнд ашиглах

Уурхайн шүүрлийн усны дээжийг 2, 3 дугаар улиралд Газаргүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны лаборатори, “Монгол-Ус” ТӨҮГ, МХЕГ-н Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид ерөнхий хими, хүнд металлын шинжилгээнд хамруулж технологийн зам усалгаанд ашиглаж байна. 2022 оны 09 сарын 30-ний өдрийн байдлаар Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл – 45,791.0 шоо метр ус ашигласан байна.



Зураг 12. Шүүрлийн усны дээж авалт

2. Түвшин буйр, тахилтын булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах

Уурхай орчмын уст цэгүүд болох Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булаг ойр орчмын хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж байна.



Зураг 13. Уст цэгүүд орчмын хог хаягдлын цэвэрлэгээ

2.3 Хөрсөн бүрхэвч газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт

1. Засварын цехүүдэд аюултай хог хаягдлын түр хадгалах цэг байгуулах

Засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос маслыг түр хадгалах 20тонн багтаамжтай 2 ширхэг ёмкосыг тусгайлан засаж цементелсэн талбайд байрлуулсан.



Зураг 14. Хаягдал тос масло түр хадгалах цэг

2. Түлш шатах, тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах

Асгаралтаас хамгаалах иж бүрдлийг шаардлагатай газруудад байрлуулан асгаралт үүссэн тохиолдолд ашиглаж байна. Мөн хөрсний бохирдолыг саармагжуулах, цэвэршүүлэх зорилгоор

“Ашигтай бичил биетний био бэлдмэл EM-1” ашиглаж байна. Дээрх бодисыг засварын газар, түлш түгээх цэг, генераторуудын орчимд ашиглаж байна.



Зураг 15. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл, ашигатай бичил биетний биобэлдмэл EM-1

3. Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавьна (шинээр хөрс хуулах тохиолдол бүр)


Тус онд засварын газрыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотойгоор 14 га, 140,195м² талбайгаас 8,200.7 м³ шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолгод стандартын дагуу хадгаласан. Уурхайн шимт хөрсний овоолгод 67,979.04 м³ шимт хөрс хадгалагдаж байна. Овоолго дахь шимт хөрсийг хамгаалах ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэн хөрс авч ажилчдын кемп орчмын ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 16. Хуулсан шимт хөрс тээвэрлэлт



Зураг 17. Шимт хөрснөөс авч оффис орчимд ногоон байгууламж байгуулсан.



Зураг 18. 2022 онд хуулсан шимт хөрсний хэмжээ

2.4 Амьтны аймаг

1. Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээг авах

Биотехникийн арга хэмжээ: Цэцэг сум, Мянган угалзатын нурууны тусгай хамгаалалттай газар

Ховд аймаг Цэцэг сумын Мянган угалзатын нурууны тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт Цэцэг нуур багийн ИНХ-ын дарга О.Бямбацоож, Баянгол багийн иргэн П.Баярсайхан, Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч тусгай хамгаалалттай газар нутгийн аргаль, янгир нутагладаг газрууд болох Цахир хамар, Яргайтын хад, Хархөтөл гэх газруудад 200 пресс өвс, 1.5 тонн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан.




Зураг 19. Цэцэг сум Зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

2.5 Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбайд үүсэх тоосжилт бий болохоос сэргийлж тоос дарагч мананжуулагч машиныг үргэлжлүүлэн ашиглана.

Хуурай баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбайн ачилтын талбайгаас үүсэх тоосны хэмжээг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах үүднээс 4 мананжуулагч машинаар мананжуулах усалгаа хийж байна. Мананжуулагч машин нь агаарт дэгдэх тоос руу усыг мананцар болгон өндөр даралтаар цацснаар барьцалдуулан газарт буулгадаг ач холбогдолтой. 2022.09.30-ны өдрийн байдлаар үйлдвэрлэлийн усны хэрэглээнд – 23,592 шоо метр ус зарцуулсан байна.



Зураг 20. Нүүрсний талбайд ажиллаж байгаа мананжуулагч машин



Зураг 21. Хуурай баяжуулах үйлдвэр, экспортын нүүрс ачилт, буулгалтын талбай

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн зориулалт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	-	Тухай бүр	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний шинэ овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулах ажлыг үргэлжлүүлэх, олон наст ургамлын туршилт хийх	21,300,000	Нэг удаа	Уурхайн шимт хөрсний овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулж олон наст тэжээлийн ургамал тариалсан. <u>Дэлгэрэнгүйг тус тайлангийн 3.1 дүгээр бүлгээс харна уу.</u>	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS_5916_2008
3		Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх мод тарих	-	Нэг удаа	Намрын тарилтаар ойжуулах ажлыг Цэцэг суманд 2 га газарт 2000 ширхэг бургас, улиасны суулгацыг тарьж байна.	
4	Татан буулгах, хаалтад бэлтгэх	Одоогоор татан буулгах, хаалтад бэлтгэх талбай байхгүй.	-	Тухай бүр	Одоогоор татан буулгах, хаалтад бэлтгэх талбай байхгүй.	Байгаль орчны аудитын үл нийцлийг арилгах төлөвлөгөө
Нийт зардал, мян.төг					21,300,000	

3.1 Биологийн нөхөн сэргээлт


1. Шимт хөрсний шинэ овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулах ажлыг үргэжлүүлэх, олон наст ургамалын туршилт хийх

Уурхайн шимт хөрсний талбайн үржил шимийг урт хугацаанд хадгалах зорилгоор ургамалжуулж Ботуул, Ерхөг, Өлөнгө олон наст ургамлыг үрээр тариалсан.

Шимт хөрсний талбайгаас дээж авч улиралд 1 удаа Улаанбаатар хот “Шинжлэх ухааны академи Газарзүй – Геоэкологийн хүрээлэн Хөрсний лабораторид” Химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн, хүнд металлын агууламжыг тодорхойлуулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна. Мөн 2022 оны 5 дугаар сард уурхайн шимт хөрснөөс дээж авч МХЕГ-ын ХАБҮЛ лабораторид цацрагийн шинжилгээнд хамруулсан.



Зураг 22. Шимт хөрсний талбайд олон наст ургамалын үр тариалсан



Зураг 23. Шимт хөрсний талбайд хадгалагдаж байгаа шимт хөрсний хэмжээ

2. Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх мод тарих

Уурхайн ойр орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Намрын тарилтаар ойжуулах ажлыг Цэцэг суманд зохион байгуулж байна. Тус сумын нутагт зам дагуу 2 га газрыг хашиж хамгаалан, тор татаж 2000 ширхэг бургас, улиасны суулгац суулгасан.



Зураг 24. Цэцэг суманд ойн зурвас байгуулах ажлын үйл явц

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Үенч сумын төвд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Үенч сумын санал/	Үенч сум	21,217,100	Нэг удаа	Үенч сумаас ирсэн саналын дагуу Үенч сумын төвд эвдэрсэн 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх, эвдэрсэн газрыг тэгшлэх, нөхөн дүүргэх, гадаргууг хэлбэршүүлэх ажлыг шат дараатай хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.1 дүгээр бүлгээс харна уу.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2		Алтай суманд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал/	Алтай сум	5,990,430	Нэг удаа	Алтай сум, БОАЖГ-с ирсэн саналын дагуу Алтай сумын Алтангадас багт Майхан хар нэртэй газар 5 га, Хөндийн ам гэх газарт 3 га талбайд гар аргаар алт олборлоход өртөж эвдэрсэн газрыг тэгшлэх, нөхөн дүүргэх, гадаргууг хэлбэршүүлэх техникийн нөхөн сэргээлтийн ажлыг шат дараатай хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.1 дүгээр бүлгээс харна уу.	
3	Дүйцүүлэн хамгаалах нэмэлт ажил	Цагаан түнгэ, Улиаст, Нарийн гол, Жаргалан булгийн эх хамгаалах	Дарви, Үенч	-	Нэг удаа	Ховд аймгийн Үенч сумын Цагаан түнгэ, Нарийн гол багийн нутгуудад усны эх, булаг шанд хамгаалах ажлыг хийж гүйцэтгэн 4 булгийн эхийг хамгаалж сум орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Мөн Дарви сумын Мөнгөн аяга багийн Тунгалгийн булгийн усыг хашиж хамгаалан сум орон нутагт хүлээлгэн өгч, Мөрөн багийн Цагаан давааны булгийн эхийн торыг шинэчилж, ус тогтоох далан хийж байршуулсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.1 дүгээр бүлгээс харна уу.	Үенч сум ЗД
4		Сумдын байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтыг Ховд аймгийн БОАЖГ-тай хамтран зохион байгуулах	Ховд аймаг, сумдын байгаль хамгаалагчид	0	Нэг удаа	Тус сургалтыг аймгийн БОАЖГ-аас зохион байгуулхаар төлөвлөсөн. Сургалт зохион байгуулагдах үед хамтран зохион байгуулна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.1 дүгээр бүлгээс харна уу.	Ховд аймгийн БОАЖГ санал

5		Сонгогдсон идвэхтэн байгаль хамгаалагчид байгаль хамгаалагчийн өвлийн хувцас, дурангаар дэмжлэг үзүүлэх	Идвэхтэн байгаль хамгаалагч	0	багц	Дарви сумын Мөрөн багийн сутаин баялаг мөрөн болон Баян хөвхөр нөхөрлөлийн идвэхтэн байгаль хамгаалагч болох С.Жамбалдорж, Ц.Заяат нарт хоёр нүдний дуран, өвлийн байгаль хамгаалагчийн хувцасаар дэмжлэг үзүүлсэн.	Ховд аймгийн БОАЖГ санал
6	Дүйцүүлэн хамгаалах урт хугацааны төлөвлөгөө	Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх	Дүйцүүлэн хамгаалах талбай	844,000	Тогтмол	Сутай хайрхан уулын авиралтыг МоЭнКо ХХК-ийн 4 ажилтан, хөтөч, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 4 албан хаагчтай хамтран зохион байгуулсан. Тоосонцрын хэмжээг тодорхойлохоор тоосны хэмжилтийн Dusttruck багажыг РМ 2.5, РМ 10 хошуугаар 3 цэг авч хэмжилт хийсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.2 дугаар бүлгээс харна уу.	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд
7		Дүйцүүлэн хамгаалах талбайд худаг гаргах	Дүйцүүлэн хамгаалах талбай	38,500,000	Нэг удаа	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд малчид, ойжуулалт мод усалгаанд зориулсан хурдгийг гаргаж тохижуулах ажлыг мэргэжлийн байгууллага болох Алтайн хар сувд ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.2 дугаар бүлгээс харна уу.	Дарви сум ЗД санал
8		Дүйцүүлэн хамгаалах талбайн шинэсэн ойд орон нутгийн ойн нөхөрлөлтэй хамтран тариалалт хийх	Дүйцүүлэн хамгаалах талбай	-	Нэг удаа	Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 1 сая мод тарьж ургуулах амлалт авч 2022 оны намрын тариалалтаар 20000 суулгац тарьж эхлүүлсэнтэй холбоотойгоор тухайн ажлыг хойшлуулсан байгаа.	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
9		Өвөл, хаврын улиралд цаг хүндэрсэн тохиолдолд зэрлэг ан амьтанд био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх /Өвс, хужир, шүү/	Дүйцүүлэн хамгаалах талбай	3,870,000	Тухай бүрд	2022 оны 03 дугаар сард Ховд аймгийн Үенч сумдын тусгай хамгаалалттай газар нутгуудаар зэрлэг ан амьтад нутагладаг, үр төлөө гаргадаг газруудаар амьтдад 300 пресс өвс, 3тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Мөн 2022.03.22-нд Ховд аймаг Цэцэг сумын Мянган угалзатын нурууны тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт Цэцэг нуур багийн ИНХ-ын дарга О.Бямбацоож, Баянгол багийн иргэн П.Баярсайхан, Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч тусгай хамгаалалттай	Дүйцүүлэн хамгаалах урт хугацааны төлөвлөгөө

						газар нутгийн аргаль, янгир нутагладаг газрууд болох Цахир хамар, Яргайтын хад, Хархөтөл гэх газруудад 200 пресс өвс, 1.5 тонн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.2 дугаар бүлгээс харна уу.	
10	МоЭнКо ХХК-ийн хэрэгжүүлэх нэг сая мод хөтөлбөр	Алим жимс, жимсгэний модны суулгац хүлээлгэн өгөх /Үенч сумын санал/	Үенч сум	7,850,000	Нэг удаа	Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн, МоЭнКо ХХК-ийн хэрэгжүүлэх нэг сая мод хөтөлбөрийн хүрээнд, 2022 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд Үенч сумын ЗДТГ-аас ирсэн ажлын саналыг хэрэгжүүлэх зорилгоор 200 ширхэг (Бэсрэг алим-100 ш, Слив-100ш) модны суулгацыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.3 дугаар бүлгээс харна уу.	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн
11		Булган голын ай сав дагуу улсын тусгай хамгаалалттай газарт бургас тариалах ойжуулах ажилд туслалцаа үзүүлэх /Булган сумын санал/	Булган сум	166,320,000	Нэг удаа	Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 1 сая мод тарьж ургуулах амлалт авч, хариуцлагын гэрээнд гарын үсэг зурж батламжилсан. Тус ажлын хүрээнд 2022 онд хийгдэх ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган Дарви саманд 10000 ширхэг, Цэцэг суманд 2000 ширхэг, Алтай суманд 2000 ширхэг, Булган суманд 6000 ширхэг нийт 20000 ширхэг суулгацаар ойн зурвас байгуулах ажлыг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.3 дугаар бүлгээс харна уу.	
12		Алтай сумын Барлаг, Алтангадас багийн төв орчимд ойн зурвас байгуулах /Алтай сумын санал/	Алтай сум		Нэг удаа		
13		Дарви, Цэцэг сумдад ойн зурвас байгуулах /Дарви сумын санал/			218,744,180		
Нийт зардал, мян.төг						463,335,710	

4.1 Дүйцүүлэн хамгаалах нэмэлт ажил

1. Үенч сумын төвд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Үенч сумын санал/

Үенч сумаас ирсэн саналын дагуу Үенч сумын төвд эвдэрсэн 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх, эвдэрсэн газрыг тэгшлэх, нөхөн дүүргэх, гадаргууг хэлбэршүүлэх ажлыг шат дараатай хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн.

Нэмэлтээр: Сумын төвийн зам дагуу эвдэрсэн газруудыг засварлах, хөмсөг татах зэрэг ажлуудыг хийсэн.

Ажил эхлэхийн өмнө



Ажил дууссны дараа



Зураг 25. Үенч сум 10 га техникийн нөхөн сэргээлт

2. Алтай суманд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал/

Алтай сум, БОАЖГ-с ирсэн саналын дагуу Алтай сумын Алтангадас багийн Майхан хар нэртэй газарт 5 га, Хөндийн ам гэх газарт 3 га эвдэрсэн газрыг тэгшлэх, нөхөн дүүргэх, гадаргууг хэлбэршүүлэх техникийн нөхөн сэргээлтийн ажлыг шат дараатай хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн.

Ажил эхлэхийн өмнө



Ажил дууссны дараа



Зураг 26. Алтай сум Майхан хар 5 га техникийн нөхөн сэргээлт

Ажил эхлэхийн өмнө




Ажил дууссны дараа



Зураг 27. Алтай сум Хөндийн ам 3га техникийн нөхөн сэргээлт

3. Цагаан түнгэ, Улиаст, Нарийн гол, Жаргалан булгийн эх хамгаалах /Үенч, Дарви/

Ховд аймгийн Үенч сумын Цагаан түнгэ, Нарийн гол багийн нутгуудад усны эх, булаг шанд хамгаалах ажлыг хийж гүйцэтгэн 4 булгийн эхийг хамгаалж сум орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Мөн Дарви сумын Мөнгөн аяга багийн Тунгалгийн булгийн усыг хашиж хамгаалан сум орон нутагт хүлээлгэн өгч, Мөрөн багийн Цагаан давааны булгийн эхийн торыг шинэчилж, ус тогтоох далан хийж байршуулсан.



Зураг 28. Үенч сум Цагаан түнгэ багт Шалын хотгорын булаг хамгаалсан байдал



Зураг 29. Үенч сум Нарийн гол багт Байшинт адаг усны булаг хамгаалсан байдал



Зураг 30. Үенч сум Нарийн гол багт Улиасны булаг хамгаалсан байдал



Зураг 31. Үенч сум Жаргалангийн гол Яргайтын булаг хамгаалсан байдал



Зураг 32. Дарви сум Тунгалгийн булгийн эхийг хашиж хамгаалсан байдал



Зураг 33. Дарви сум Цагаан давааны булгийн сэргээж зассан байдал

4.2 Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжих урт хугацааны төлөвлөлтийн хүрээнд хийгдэх ажлууд


Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх

2021 оны 3-р сарын 25-ний өдөр МоЭнКо ХКК, “Монгол орны хүйтэн мандал судлалын төв” ТББ хамтран ажиллах гэрээ байгуулснаар энэхүү судалгааны ажил эхэлсэн.

Энэхүү судалгааны зорилго нь Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаа Сутай хайрхан уулын мөнх цасанд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг судлах зорилго тавьсан.

Сутай хайрхан уулын авиралтыг МоЭнКо ХХК-ийн 4 ажилтан, хөтөч, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 4 албан хаагчтай хамтран зохион байгуулсан.

Тоосонцрын хэмжээг тодорхойлохоор тоосны хэмжилтийн Dusttruck багажыг PM 2.5, PM 10 хошуугаар 3 цэг авч хэмжилт хийсэн.



Зураг 34. Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгааны авиралт

2. Дүйцүүлэн хамгаалах талбайд худаг гаргах

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд малчид, ойжуулалт мод усалгаанд зориулсан худгийг гаргаж тохижуулах ажлыг мэргэжлийн байгууллага болох Алтайн хар сувд ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.



Зураг 35. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд гаргасан худаг

3. Өвөл, хаврын улиралд цаг хүндэрсэн тохиолдолд зэрлэг ан амьтанд био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх /Өвс, хужир, шүү/

Биотехникийн арга хэмжээ: Үенч сум, Үенч сумын тусгай хамгаалалттай газар

Ховд аймгийн Үенч сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг ан амьтад нутагладаг газруудад Үенч сумын байгаль хамгаалагч Н.Эрхэм, ТХГ нутгийн байгаль хамгаалагч Ж.Ариунбат нарын ахласан баг бүрэлдэхүүнтэй хамтран зэрлэг ан амьтдад өвс, хужир тавьж өгөх биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Тус ажлын хүрээнд сумын төвөөс 60 км зайд тусгай хамгаалалттай газар нутагт байрлах Дэрстэйн эх хөндлөн гэх янгир ямаа нутагладаг, үр төлөө гаргадаг газарт 100 пресс өвс, 1 тонн хужир тавьж өгсөн.

Мөн Ховд аймаг Цэцэг сумын Мянган угалзатын нурууны тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт Цэцэг нуур багийн ИНХ-ын дарга О.Бямбацоож, Баянгол багийн иргэн П.Баярсайхан, Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч тусгай хамгаалалттай газар нутгийн аргаль, янгир нутагладаг газрууд болох Цахир хамар, Яргайтын хад, Хархөтөл гэх газруудад 200 пресс өвс, 1.5 тонн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан.

Ховд аймгийн Дарви сумын зэрлэг ан амьтад нутагладаг газруудад Дарви сумын байгаль хамгаалагч Б. Бум-Эрдэнэ нарын баг бүрэлдэхүүнтэй хамтран зэрлэг ан амьтдад өвс, хужир тавьж өгөх биотехникийн арга хэмжээ авч ажилласан.

Тус ажлын хүрээнд сумын төвөөс 40 км зайд тусгай хамгаалалттай газар нутагт байрлах Цагаан ар гэх янгир ямаа нутагладаг, үр төлөө гаргадаг газарт 200 пресс өвс, 1 тонн хужир тавьж өгсөн.





Зураг 24. Үенч сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ



Зураг 36. Дарви сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

4.3 МоЭнКо ХХК-ийн хэрэгжүүлэх нэг сая мод хөтөлбөр


1. Алим жимс, жимсгэний модны суулгац хүлээлгэн өгөх /Үенч сумын санал/

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн, МоЭнКо ХХК-ийн хэрэгжүүлэх нэг сая мод хөтөлбөрийн хүрээнд, 2022 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд Үенч сумаас ирүүлсэн саналыг хэрэгжүүлэх зорилгоор 200 ширхэг (Бэсрэг алим-100ш , Слив-100ш) модны суулгацыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.



Зураг 37. Үенч суманд жимсний модны суулгац хүлээлгэн өгсөн

2. Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 1 сая мод тарьж ургуулах амлалт авч, хариуцлагын гэрээнд гарын үсэг зурж батламжилсан. Тус ажлын хүрээнд 2022 онд хийгдэх ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган Дарви саманд 10000 ширхэг, Цэцэг суманд 2000 ширхэг, Алтай суманд 2000 ширхэг, Булган суманд 6000 ширхэг нийт 20000 ширхэг суулгацаар ойн зурвас байгуулах ажлыг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэсэн.



Зураг 25. Дарви сум ойжуулалт



Зураг 26. Цэцэг сум ойжуулалт



Зураг 27. Булган ум ойжуулалт



Зураг 28. Алтай сум ойжуулалт

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Малчин өрх	Нүүлгэн шилжүүлэлтийн 2-р ээлжийн ажил болох уурхайн нөлөөллийн бүсийн өвөлжөө хаваржааны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэх	Нөлөөллийн сумдын малчин өрх	Төслийн тусгай санхүүжилт	Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамтран ажиллах гэрээний хугацаанд	2022 онд Хөшөөт багийн өвөлжөө хаваржааг нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 5 өрхтэй хэлэлцээр хийж 3 гэрээг баталгаажуулж нүүлгэн шилжүүлсэн. Д.Цогтбат, Б.Гансүх, Б.Лхагвапүрэв нарын өвөлжөө хаваржаанд хөрөнгийн үнэлгээний дүнгээр хэлцэл хийж гэрээ байгуулан нөхөн төлбөр олгосон байна. Т.Амартүвшинтэй зөвшилцсөн гэрээ батлагдах шатандаа явж байна. Бадамсүрэнгийн хаваржаанд хараахан зөвшилцөлд хүрээгүй.	Байгаль орчин нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамтран ажиллах гэрээ
Нийт зардал мян.төг					-		

1. Нүүлгэн шилжүүлэлтийн 2-р ээлжийн ажил болох уурхайн нөлөөллийн бүсийн өвөлжөө хаваржааны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэх.

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарч байгаа тоосжилтод өртөж байгаа малчдад нөхөн олговор олгох ажил Дарви Мөрөн баг, Цэцэг Хажинга багийн малчин өрхүүдэд судалгааны шатандаа явагдаж байна. 2022 онд Хөшөөт багийн өвөлжөө хаваржааг нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 5 өрхтэй хэлэлцээр хийж 3 гэрээг баталгаажуулж нүүлгэн шилжүүлсэн. Д.Цогтбат, Б.Гансүх, Б.Лхагвапүрэв нарын өвөлжөө хаваржаанд хөрөнгийн үнэлгээний дүнгээр хэлцэл хийж гэрээ байгуулан нөхөн төлбөр олгосон байна. Т.Амартүвшинтэй зөвшилцсөн гэрээ батлагдах шатандаа явж байна. Бадамсүрэнгийн хаваржаанд хараахан зөвшилцөлд хүрээгүй.



Зураг 29. Нөлөөллийн бүс дэх өвөлжөө, хаваржааны судалгаа

ЗУРГАА. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэлжүүлэх	Хөшөөтийн нүүрсний уурхай орчим	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2010 онд Монгол улсын ШУА-ийн Археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний багаар судалгаа хийлгэж бүртгэлжүүлсэн археологийн 114 тооны дурсгалаас Хөшөөт-111, Хөшөөт-112, Хөшөөт-113, Хөшөөт-114 дурсгалуудыг бүртгэлжүүлж фото зураг дарж баримтжуулсан. Мөн Хөшөөт-114 дурсгалыг хашаалж хамгаалсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 6.1 дүгээр бүлгээс харна уу.	Байгаль орчин нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ
2	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Археологи Палеонтологийн судалгаа хийгдсэн	Түүх дурсгалт газруудад самбар байрлуулах	Нөлөөллийн сумууд	10,410,000	Нэг удаа	Үенч сумаас ирсэн саналын дагуу Түүх соёлын өвийг хамгаалах, сурталчилан таниулах хөтөлбөрийн хүрээнд 3x2 харьцаатай 5 ширхэг самбар хүлээлгэн өгсөн. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Үенч сумын байгалийн 9 гайхамшиг танилцуулга ✓ Үенч сум мод үржүүлгийн талбайн самбар ✓ Унаган байгаль бидний бахархал танилцуулга Мөн өнгөрсөн оны үлдэгдэл ажил болох Цэцэг сумын “ШАХААТ” нэртэй газарт Түүх соёлын өвөө хамгаалах, сурталчилан таниулах 2 ширхэг мэдээллийн самбар байрлуулах ажлыг хийсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 6.2 дүгээр бүлгээс харна уу.	Үенч сумын санал
Нийт зардал мян.төг				10,410,000			

6.1 Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэлжүүлэх

Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2010 онд Монгол улсын ШУА-ийн Археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний багаар судалгаа хийлгэж бүртгэлжүүлсэн археологийн 114 тооны дурсгалаас Хөшөөт-111, Хөшөөт-112, Хөшөөт-113, Хөшөөт-114 дурсгалуудыг бүртгэлжүүлж фото зураг дарж баримтжуулсан. Мөн Хөшөөт-114 дурсгалыг хамгаалсан.

Хөшөөт-111. Хөшөөт 111: Дугуй хүрээтэй овгор дараастай хиргисүүр бий. Хүрээний хэмжээ 1600 см, голын овгор 1200 см. Зүүн талдаа 1100 см урт, 400 см өргөн дагуултай. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'18.6''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'57.1''$ солбилцолд оршино.



Зураг 30. Дугуй хүрээтэй овгор дараастай хиргисүүр 2010-2022 он

Хөшөөт 112: Дугуй хүрээтэй нэг хиргисүүр байна. Хиргисүүрийн хүрээний голч 1700 см, голын овгор 850 см. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'22.8''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'55.8''$ солбилцолд оршино.



Зураг 31. Дугуй хүрээтэй хиргисүүр 2010-2022 он

Хөшөөт 113: Хүрээгүй дугуй чулуун овоолго бүхий байгууламж бий. Хэмжээ 900см. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'23.2''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'58.4''$ солбилцолд оршино.

2010 он

2022 он



Зураг 32. Хүрээгүй дугуй чулуун овоолго бүхий байгууламж 2010-2022 он

Хөшөөт 114: Дугуй хүрээтэй нэг хиргисүүр байна. Хүрээний голч 1300 см, голын овгор дараас 950 см хэмжээтэй. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ} 7'31.3''$, зүүн уртрагийн $93^{\circ}17'17.2''$ солбилцолд оршино.

2010 он

2022 он



Зураг 33. Хүрээ, дагуул байгууламжгүй хиргисүүр 2010-2021 он



Зураг 34. Хөшөөт 114: Дугуй хүрээтэй нэг хиргисүүрийг хамгаалсан

6.2 Уурхай орчмын түүх дурсгалын газруудад самбар хийх



Зураг 35. Үенч суманд байрлуулсан самбар

Цэцэг сумын төвөөс 15км зайд байх өндөр хар толгойн хойд үзүүрт Ард Аюуш нь Да лам Жамбаа, Гүн Маньбазар нартай зарга нэхэж шахаанд шургаж байсан түүхэн дурсгалт газар болох “ШАХААТ” нэртэй газарт Түүх соёлын өвөө хамгаалах, сурталчилан таниулах 2 ширхэг мэдээллийн самбар байрлуулсан.



Зураг 36. Цэцэг суманд байрлуулсан самбар

ДОЛОО. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
1	Аюултай бодис асгарах	Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах	Нүүрсний чанарын лаборатори, төслийн талбайн шаардлагатай газруудад	Үйл ажиллагааны зардалаас	Тухай бүр	Химийн бодисын агуулахад асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх асгаралтаас хамгаалах иж бүрдлийг байрлуулсан. Үүнд <ul style="list-style-type: none"> ✓ Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур ✓ Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн ✓ Үүссэн асгаралтыг шингээгч алчуур Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.1 дүгээр бүлгээс харна уу.
2	Аливаа халдварт өвчин бохирдолоос сэргийлэх	Ариутгал халдваргүйтгэл хийх	Уурхайн хэмжээнд	Гэрээт компанийн зардалаас	1 удаа	Ариутгал халдваргүйтгэл, шавьж мэрэгчгүйтгэл, устгалын ажлыг мэргэжлийн байгууллага болох “Ноён худаг нөхөрлөл”-тэй гэрээ байгуулан уурхайн ажлын байрууд, ажилтнуудын амрах байр, нийтийн ариун цэврийн өрөө, угаалгын газар болон уурхайн бүх хэсэгт улиралд 1 удаагийн давтамжтай хийж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.2 дугаар бүлгээс харна уу.
3	Химийн бодисын хадгалалтад хяналт тавих	Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх	Нүүрсний чанарын лаборатори	Үйл ажиллагааны зардалаас	Улирал тутам	Ашиглах зөвшөөрөл бүхий 18 нэр төрлийн химийн бодисын тооллогыг сар тутам хийж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хавсралт 2, 3
4	Химийн бодистой харьцдаг ажилчид	Агуулахад зориулалтын нүд угаах, гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг байрлуулах	Нүүрсний чанарын лаборатори	Үйл ажиллагааны зардалаас	Багц	Химийн бодисын агуулахад гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс онцгой үед ашиглах дараах хэрэслүүдийг байрлуулсан. Үүнд <ul style="list-style-type: none"> ✓ Нүд угаах цэг ✓ Галын хор /ABC 4кг нунтаг/ ✓ Анхны тусламжийн хайрцаг ✓ Тэмдэг тэмдэглэгээ, мэдээлэл Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.3 дугаар бүлгээс харна уу.
5	Гал түймэр	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах, галын хор болон самбар нэмэж байрлуулах	Хөшөөтийн уурхайн нүүрсний чанарын лаборатори	500,000	Жилийн турш	Уурхайн галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын самбар хийлгэж уурхайн төв оффисийн үүдэнд байрлуулсан. Төслийн талбайд гал түймэр гарах урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үүднээс галын хорыг нэмэгдүүлсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.4 дүгээр бүлгээс харна уу.
Нийт зардал мян.төг				500,000		

МоЭнКо ХХК нь Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газраар химийн бодисын агуулахын ажлын байранд дүгнэлт гаргуулсан. Химийн бодис хадгалах агуулах нь агааржуулалтын системтэй, галын аюулгүй ажиллагааны үед ашиглах багаж хэрэгсэл, ослын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан, байнгын харуул хамгаалалттай, химийн бодисын хор аюулын таних тэмдэглэгээг байрлуулсан байна. Энэхүү химийн бодисын агуулах нь химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартад тавигдах шаардлага хангасан гэж дүгнэсэн.

“Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”, “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг чанд баримтлан ажиллаж байна. Химийн бодис асгарсан тохиолдолд ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд байршуулж, ажилчдад ашиглах дадлыг эзэмшүүлэх, химийн бодисын хог хаягдлыг аюултай хог хаягдал устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэх хүртэл түр хадгалах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэн, химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодлыг импортлогч руу нь буцаадаг. Мөн аврах зам, гарц, цугларах цэг, анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, чиглэлийн заасан тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулсан.



Зураг 37. Химийн бодисын хадгалалт



Зураг 38. Лабораторийн шинжилгээний үйл явц

7.1 Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах

Химийн бодисын агуулахад асгаралт үүссэн онцгой нөхцөл байдалд хэрэглэх зорилгоор асгаралтаас хамгаалах иж бүрдлийг байрлуулсан. Үүнд

- ✓ Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур
- ✓ Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн
- ✓ Үүссэн асгаралтыг шингээгч алчуур



Зураг 39. Химийн бодисын агуулахад байрлуулсан асгаралтаас хамгаалах иж бүрдэл

7.2 Ариутгал халдваргүйтгэл хийх

Ариутгал халдваргүйжүүлэлтийг хүний эрүүл мэнд болон хүнсний бүтээгдэхүүнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаар улиралд нэг удаа хийлгэдэг. “Ноён худаг БН” тусгай зөвшөөрөлтэй компанийн баг бүрэлдэхүүн ирж тусгай зориулалтын бодисоор ариутгал халдваргүйжүүлэлт, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэлийг 23190 мкв талбайд хийсэн.



Зураг 40. Ариутгал халдваргүйжүүлэлт

7.3 Шатах тослох материалын тосох, зөөх савыг нэмэгдүүлэх

Нүүрсний чанарын лаборатори, Хуурай баяжуулах үйлдвэрийн засварын цех, засварын газруудад асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлж Асгаралтын иж бүрдэл байрлуулсан. Асгаралт үүссэн тохиолдолд дээрхи иж бүрдлийг түргэн шуурхай ашиглах зорилгоор бэлэн байлгаж байна.



Зураг 41. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл

7.4 Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах, галын хор болон самбар нэмэж байрлуулах

Уурхайн галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын самбар хийлгэж уурхайн оффисийн үүдэнд байрлуулсан. Төслийн талбайд гал түймэр гарах урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үүднээс галын хорыг нэмэгдүүлсэн.


НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Хөшөөт төсөл аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан зохицуулахыг зорьж ажилладаг. Хог хаягдлыг дараах үе шатаар явагддаг. Үүнд:

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь арилгах болон бууруулах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах (хэрэв шаардлагатай бол сэргээн зассаны дараа)
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах. Зөвхөн үүний дараа хог хаягдлыг устгах үйл ажиллагаа явагдана.

МоЭнКо ХХК-ийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.



Схем. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Үүнд:

Хоёрдогч түүхий эд болгон ашиглах боломжтой хог хаягдал

- Хуванцар /ус, ундаа, кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав/
- Хаягдал төмөр

Бусад хог хаягдал

- Нүүрсний үнс
- Түргэн муудах хоол, хүнсний хаягдал
- Ариун цэврийн хаягдал
- Цай, кофены уут
- Сав баглаа, боодол
- Шил, лааз
- Гялгар уут
- Модон эдлэлийн хаягдал
- Хаягдал дугуй

- Резин / хаймар
- Барилгын хаягдал (тоосго, бетон, мод, тусгаарлагч болон дулаалгын материал, хадаас, цахилгааны монтаж, сантехникийн тоног төхөөрөмж, арматур, хаягдал, плита, ханын цаас зэрэг барилгын материалаас гадна суурийн шороо, огтолсон мод, чулуу зэрэг барилгын бэлтгэл ажлын явцад үүссэн хог хаягдлыг багтаана).

Аюултай хог хаягдал

- Техник тоног төхөөрөмжийн засвараас гарах хаягдал (ашигласан тос, масло, антифриз)
- Техникийн тос материалаар бохирдсон шингээгч материал, алчуур, тосны шүүр
- Түлш, техникийн тосоор бохирдсон хөрс
- Нүүрсний химийн лабораториос гарах шингэн хаягдал

Эмнэлгийн хог хаягдал

Эрүүлийг хамгаалах үйл ажиллагааны явцад үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношилгооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхт материалыг багтаана.

Түр хадгалалт, тээвэрлэлт

Хог хаягдлыг тухайн үүссэн цэг дээр нь хаягжуулалт бүхий тусгай цэгт битүү хогийн савнуудад ангилан ялгасан төрлөөр нь тусад нь хадгалах ба тээвэрлэлтийг эрх бүхий байгууллага тодорхой хуваарийн дагуу холбогдох журам стандартын дагуу хийж гүйцэтгэдэг.

Хогийн цэгийн үйл ажиллагаа

Хог хаягдлын нэгдсэн цэг дээр дараах үндсэн үйл ажиллагаа явагддаг.

Хогийн төвлөрсөн цэг дээр эх үүсвэр дээрээ ангилагдаагүй хог хаягдлыг дахин ангилан ялгах

Ангилан ялгасан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх

Дахин ашиглагдах хог хаягдлыг ялгаж ангилсны дараа дахин ашиглах боломжгүй үлдсэн хог хаягдлыг шатаах зууханд шатаах

Шатаах зуухнаас гарсан үнс нурмыг булж устгах.

Ахуйн хог хаягдлын урсгал ба зохицуулалт

Төслийн үйл ажиллагааны хог хаягдлын менежментийн дагуу эх үүсвэрээс гарсан хог хаягдлын төрөл тус бүрд нийцсэн байгаль орчинд нөлөөлөх багатайгаар зайлуулах арга замыг сонгож хэрэгжүүлдэг.

Хүснэгт 8. Ахуйн хог хаягдлын төрөл ба зохицуулалт

Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Түр хадгалалтын нөхцөл	Хогийг цуглуулах болон зайлуулах явц	Тайлбар
Ахуйн хатуу хог хаягдал				
Ахуйн нийтлэг хог хаягдал	Ажилчдын кемпүүд, оффис	Хаягжуулсан саванд	Хог хаягдлыг ангилан ялгах, булшлах	Эрх бүхий ААН болон хувь хүмүүст өгөх
Цаасны хаягдал	Ажилчдын хотхон, Оффисууд,	Хаягжуулсан саванд	Дахин ашиглах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	
Хуванцар сав	Ажилчдын хотхон, Оффисууд	Хаягжуулсан саванд	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	
Ахуйн шингэн хаягдал				
Бохир ус	Ажилчдын хотхон, оффисууд	Зориулалтын танк	Ховд аймгийн цэвэрлэх байгууламж руу зөөх	Одоогоор цэвэрлэх байгууламж баригдаагүй тул зөөвөрлөж байна.
Хоолны үлдэгдэл	Хоолны газар	Хаягжуулсан саванд	Хоолны үлдэгдлийг нуггийн иргэдэд нохой, гахайн тэжээл болгон өгөх	Илүүдэл хаягдлыг булшилж устгах
Үйлдвэрлэлийн хатуу хаягдал				
Барилгын хаягдал	Барилга баригдсан талбай	Барилгын талбайд	Булшилж устгах	-
Хаягдал дугуйнууд	Засварын төв, Автопарк	Тусгай талбайд	Дахин ашиглах, Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх,	Замын хаалт, тэмдгийн сууриар ашиглах
Поошиг	Уурхайн засварын төв	Тусгай талбайд	Цэвэрлээд хогийн сав болон хашааны материалд дахин ашиглах,	Замын тэмдгийн сууриар ашиглах
Төмөр	Төслийн нэгжүүд	Дахин ашиглах хаягдал цуглуулах цэгт	Дахин боловсруулах зорилгоор зах зээлд нийлүүлэх	Дахин боловсруулах компани болон хувь хүмүүст өгөх
Модон материалын хаягдал	Төслийн нийт нэгжүүдэд	Дахин ашиглах хаягдал цуглуулах цэгт	Дахин ашиглуулах зорилгоор нийлүүлэх	Орон нутгийн иргэдийн хэрэгцээнд өгөх

Аюултай хог хаягдлын хадгалалт, зохицуулалт

Химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон цэгт холбогдох журмын дагуу хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хоргүй буюу аюулгүй аргаар устгах бөгөөд энэхүү ажиллагаанд тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, эрүүл ахуйн улсын байцаагч, онцгой байдлын асуудал хариуцсан мэргэжилтнээс бүрдсэн комиссыг байлцуулна. Уг комисс химийн хорт болон аюултай бодисын хаягдал устгасан тухай акт үйлдэж, сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ гэж хуульчилсныг дагаж мөрдөх ба Монгол улсын хувьд одоогоор тусгай зориулалтын зайлуулах цэг байхгүй учраас хадгалах арга хэмжээ авна.


Хүснэгт 9. Аюултай хог хаягдлын төрөл ба зохицуулалт

Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Хадгалалт-ын нөхцөл	Хогийг цуглуулах болон зайлуулах явц	Тайлбар
Тосоор бохирдсон хаягдал даавуу алчуурууд, төрөл бүрийн тосны шүүр	Засварын төвүүд	Хаягжуулсан саванд	Зориулалтын шатаах зууханд устгах	Шатаалтын Үнсийг булшлах, төмрийг ангилан ялгах
Тос, тосолгооны материал	Үйлдвэр, засварын төв	Зориулалт-ын танканд	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Эрх бүхий ААН ба компанид
Аккумулятор	Засварын төвүүд	Тусгай талбайд	Худалдан авагч талд нийлүүлэх	-
Химийн бодисын хаягдал, сав баглаа	Угаалга, лаборатори	Бодисын агуулах	Бодисын агуулах, тусгай талбайд хадгална	Холбогдох хууль, журмын дагуу
Үнс	Цахилгаан станц	Нэгдсэн бункерийн систем	Булшилж устгах, Барилгын материалд ашиглах	-
Эмнэлгийн хог хаягдал	Анхны тусламжийн нэгж	Тусгай түр хогийн сав	Цэцэг сум	Зориулалтын дагуу хадгалах



Зураг 42. Аюултай хог хаягдлын ангилан ялгалт

ХӨШӨӨТ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАРЧ БУЙ ХОГ ХАЯГДЛЫН ТӨРЛҮҮД, ЗАЙЛУУЛЖ БУЙ АРГА ЗАМ



НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Ахуйн	Зам талбайд хийсч гарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхайн талбай	1,250,000	Улиралд	Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээ, бүх нийтийн их цэвэрлэгээ, нүүрс тээврийн зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийж байна. Бүх нийтийн цэвэрлэгээг нийт 3 удаа, орчны хог хаягдлын цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа хийж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.1 дүгээр бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
УС, ХИМИЙН БОДИСЫН АШИГЛАЛТ, ҮҮСЭН ХОГ ХАЯГДЛЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ**

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг

Регистрийн дугаар	5	1	4	1	5	8	3
Аж ахуйн нөхц, байгууллагын нэр	Мо Эн Ко ХХК						
Байршил		Нэр		Код			
Аймаг, нийслэл	Ховд						
Сум, дүүрэг	Дарвин						
Баг, хороо	Мөрөн						
Гудамж, хороолол							
Байр, байшин							
Хашаа, хаалганы дугаар							
Утас	70110563						
Факс							
Цахим шуудан							
Цахим хуудас	http://						

2. Ерөнхий мэдээлэл

Ашигт малтмалын төрөл				Чулуун нүүрс
Тусгай зөвшөөрлийн дугаар				1414А, 1640А, 4322А, 6525А, 11387А, 15239А, 20299А, 11388А
Тусгай зөвшөөрлийн талбай, га	1	8	8	8
Уулын адалбар газрын хэмжээ, га	1	0	0	0
Ашиглалт эхэлсэн он	2	0	1	0
Ашиглалтын төрөл	Ил			
Баяжуулах технологийн төрөл	Хуурай			
БОНБНГ хийсэн байгууллага	"Олт Оус" ХХК			
БОНБНГ хийсэн он	2	0	2	1

3. Уул уурхайн ашиглалт, нөхөн сэргээлт

Түүшлэл	Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Гүйцэтгэл
А	Б	В	Г
3.1. Ашигласан талбай			
Ашиглалт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Ашигласан талбай	талбай	100.45
	Хаягдал чулуулгийн талбай	га	50,383.734
	Овоолго	мян.мб	-
	Хөрсний овооло	га	178.98
		м	100
		га	10.13
Ашиглалт хийсэн талбайг онд	Ашигласан талбай	талбай	10,101.399
	Хаягдал чулуулгийн талбай	га	-
	Овоолго	мян.мб	-
	Хөрсний овооло	га	21.85
		м	90
		га	-
3.2. Техникийн нөхөн сэргээлт			

Activate Windows
 Go to Settings to activate Windows.

БОНБУ-д заасан техникийн нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	талбай	га	13	
	сэргээлт хийсэн	мян.мб	14	
Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай, өссөн дүнгээр	талбай	га	15	
	сэргээлт хийсэн	мян.мб	16	
Тайлан тугацаанд ашигласан талбай	Техникийн нөхөн сэргээлт хийсэн	га	17	
	Биологийн нөхөн сэргээлт хийсэн	га	18	
	Техникийн нөхөн сэргээлт хийсэн	га	19	
	сэргээлт хийсэн	мян.мб	20	
3.3. Биологийн нөхөн сэргээлт				
БОНБУ-д заасан биологийн нөхөн сэргээлт хийлгэх нийт талбайн хэмжээ		га	21	
Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай, өссөн дүнгээр		га	22	
Тайлан тугацаанд ашигласан талбай	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	га	23	
	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	га	24	
	Нөхөн сэргээлт хийсэн талбай	га	25	
3.4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөгжлөлтөөр зааснаас гадна хэрэгжүүлсэн				
	Дүйцүүлэн хамгаалсан газар	га	26	
3.5. Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны				
	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	сая.төг	27	
3.6. Тайланг онд байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгө				
	Тайланг тугацаанд	сая.төг	28	229,598.00
	Байгаль хамгаалах зардал	сая.төг	29	652,797.27
	Техникийн нөхөн сэргээлтийн зардал	сая.төг	30	
	Биологийн нөхөн сэргээлтийн зардал	сая.төг	31	48,215.90

Activate Windows
 Go to Settings to activate Windows.

4. Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар, нөхөн сэргээлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Гүйцэтгэл
A	Б	В	Г
Хөрс хуулалт хийсэн, эвдэрсэн газрын нийт хэмжээ (мд31 мд38)	га	1	304.35
Зам, шугам сүлжээний газар	га	32	17.6
Цахилгаан шугам сүлжээ, өндөр хүчдэл	га	33	
Төрийн хамгаалалт, далан	га	34	
Хог хаягдлын далан	га	35	0.83
Барилга, байгуулалт	га	36	13.13
Шатахуун түлээлүүр	га	37	0.53
Нөмөлт нөөц ийн хамгуулаар эвдэрсэн газрын хэмжээ	га	38	
Бусад	га	39	
Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	га	40	
Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	га	41	
Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал	аят төг	42	

5. Ус, химийн бодисын ашиглалт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Гүйцэтгэл
A	Б	В	Г
Ус ашиглах дүгнэлт гаргуулсан эсэх, ямар байгууллагаар хэдэн онд	0	42	БСАХК усны нөөцийн өвчлөл 2013 он 10 сарын 15 ны 05 дугаартай тогтоолоор. Хөшөөтийн хөндийн газар дотор усны ашиглах боломжит нөөцийн таллан
Ус ашиглах эх үүсвэр	-	43	Газар доорхи ус, well-2 дугаартай ашиглалтын худаг
Ашигласан усны хэмжээ	м ³ /с	44	111,857.86
Дахин ашиглах усны хэмжээ	мян.м ³	45	13,243.86
Усны нөөцийн хэмжээ, /Б, С зэргээр/	м ³	46	Үйлдвэрлэлийн С зэргээр 16.5 л/с бууд 1598.4 м ³ /онго
Усны дүгнэлтийн огтоо, дугаар	-	47	2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн №1/261 тоот дүгнэлт
Ашиглалтанд өртөн ойн бүрхэвчийн талбайн хэмжээ	га	48	
Химийн хорт, акултай бодисын зарцуулалт	-	49	16- нэр төрөл
Зөвшөөрөгдсөн хэмжээ	кг	50	
Ашигласан хэмжээ	кг	51	1994 литр, 127.4 кг

6. Үүссэн хог хаягдал

Агуу хатуу хог хаягдал	кг	52	9.668
Агуу шингэн хог хаягдал	мян.м ³	53	
Агуу бохир ус	тонн	54	784
Үйлдвэрийн хатуу хог хаягдал	кг	55	
Үйлдвэрийн шингэн хог хаягдал	мян.м ³	56	
Үйлдвэрийн бохир ус	мян.м ³	57	
Дахин ашигласан хатуу хог хаягдал	кг	58	3,840
Асуулын хог хаягдал	кг	59	72.5

ТАМГА Захирал/ Эзэн /
 Нягтлан бодогч /

2021 . . оны . . -р сарын . . -ны өдөр

Activate Windows
 Go to Settings to activate Windows.

ХАВСРАЛТ 7. Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 29 өдөр

Дугаар Т/Н

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай


Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны т/16-15-05 тоот дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:


Нэг. Ховд аймгийн Дарви сумын нутагт орших "МоЭнКо" ХХК-ийн Хөшөөтийн нүүрсний ордын баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

Хоёр. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

Гурав. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

Дөрөв. Ховд аймгийн Дарви сумын нутагт орших "МоЭнКо" ХХК-ийн Хөшөөтийн чулуун нүүрсний ордын баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл, бичвэр, дискийн хамт ЭБМЗ-ийн хурагдааны тэмдэглэл, дүгнэлт, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологи мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөхийг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д даалгасугай.

ДАРГА  Б. БААТАРЦОГТ



10 0486

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗАР ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

2016 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар т/16-15-05

Улаанбаатар хот

Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордын баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хэлэлцсэн тухай

"МоЭнКо" ХХК-ийн захиалгаар Геологи уул уурхайн зураг төсөл, судалгааны "Гложөкс" ХХК-ийн төслийн багийн боловсруулсан Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордын баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, зөвлөсөн Монгол улсын зөвлөх инженер Ц.Цэгмэд, Монгол Улсын Зөвлөх инженер Д.Эрдэнэчимэг шинжээчийн дүгнэлтийг авч хэлэлцээд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордын баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол (ТЭЗҮ) нь ордын товч танилцуулга, ордын геологи ил уурхай, нүүрсний шинж чанар, нүүрсний баяжигдах шинж чанарын судалгаа, нүүрс баяжуулах технологи, дэд бүтэц хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо гэсэн үндсэн 163 хуудас тайлбар бичиг бүхий 11 бүлэг, 11 ширхэг хавсралт материал, 5 ширхэг хавсралт зургуудаас бүрдэж байна.
2. Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2015 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны ХХ-11-05/01, ХХ-11-05/02, ХХ-11-05/03, ХХ-11-05/04, ХХ-11-05/05, ХХ-11-05/06, ХХ-11-05/07, ХХ-03-08/01, ХХ-03-08/02 дүгнэлтүүдийг үндэслэн Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордод 2007, 2008-2014 онуудад гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан (ордын нөөц 2015 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар) дахь "Хөшөөт" нэртэй MV-1414, MV-1640, MV-6525, MV-4322, MV-11887, MV-11888, MV-15289, MV-020299 тоот тусгай зөвшөөрлүүдийн талбайд хамаарагдах бодитой болон боломжтой (B+C) зэргээр нүүрсний нөөцийг 120,205.36 мян.тн-оор зохиогчийн хувилбараар хүлээн авсан байна.
3. "МоЭнКо" ХХК-ийн захиалгаар "Ай Эм Кэй" ХХК нь Хөшөөтийн нүүрсний ордын хуурай баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар батлуулан 2013 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн дүгнэлт гарсан байна. Төслийг хэрэгжүүлэгч "МоЭнКо" ХХК нь Хөшөөт нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийг 2014 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс ажиллуулж эхэлсэн ба улмаар ордын С, В давхаргаас нүүрсний олборлолтыг хийж нүүрсээ борлуулж байна.
4. Төсөл хэрэгжүүлэгч нь Хөшөөтийн ордод 2007, 2008-2014 онуудад нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж Хөшөөтийн ордын нөөцийн тайланг

боловсруулж 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг шинэчлэн бүртгүүлсэн байна. Иймд ордын шинэ нөөцөд тулгуурлан техник, эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) дахин тодотгох шаардлагатай болсон юм.

5. Хөшөөтийн ордод эдийн засгийн үр ашигтай бодитой В зэргээр 87.9 сая.тн нүүрс, боломжтой С зэргээр 32.2 сая.тн нүүрс, (В+С) зэргээр нийтдээ 120.2 сая.тн нүүрс нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаар улсын нөөцөд бүртгүүлсэн. Хөшөөтийн ордод шинээр батлуулсан нөөцөд тулгуурлан ил уурхайн хэсгийн техник, эдийн үндэслэлийн тодотголыг Уул уурхайн хүрээлэнгийн төслийн багийнхан Micro Mine программ ашиглаж төлөвлөлтийг гаргасан. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ил уурхайн хил хязгаар доторх геологийн нөөц 84.58 сая тн -оос технологийн болон ашиглалтын хаягдлыг 10.6%, чулуулгийн бохирдлыг 10.3%-иар тооцож, магадласан үйлдвэрийн (В) зэрэглэлийн нөөц 84.36 сая тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Хөшөөтийн нүүрсний уурхайг ашиглалтын 25 жилийн хугацаанд 237.5 сая. м³ хөрс хуулалтыг хийж, 22.6 сая.тн Ч2 буюу эрчим хүчний нүүрс, 18.9 сая.тн Ч3 маркийн нүүрс, 42.9 сая.тн Ч4 маркийн нүүрсийг олборлох ба хөрс хуулалтын дундаж коэффициент 2.81 м³/тн байна.

6. Ил уурхайд уламжлалт өрөмдлөг тэсэлгээ, ухааж ачих болон тээвэрлэх гэсэн үндсэн процессууд хэрэгжинэ. Ил уурхайд Atlas Copco үйлдвэрийн DM 45Hr маркийн өрмийн машин, хөрс тээвэрт Liebherr R954C маркийн экскаватор, "Caterpillar" CaT 772 маркийн автосамосвал, мөн ашиглалтын 2-р хэсгээс эхлэн нэмж Liebherr R9100 маркийн экскаватортай хослон "Caterpillar" CaT 777G маркийн автосамосвал, нүүрсний тээвэрт Liebherr R954C маркийн экскаватортай хослон "Caterpillar" CaT 772 маркийн автосамосвал, хөрсний овоолгод асгац түрэх, мөргөцөгт тэсэлгээгээр үүсэх нурлын хормой шуух ажилд АНУ-ын CAT D9T маркийн бульдозер зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

7. Хөшөөтийн ордын нүүрсний баяжигдах шинж чанарын судалгаа, технологийн туршилт шинжилгээг БНХАУ-ын Нүүрсний Геологийн ерөнхий газрын төв лабораторид гүйцэтгүүлсэн бөгөөд 2012 онд үйлдвэрлэлийн урьдчилсан зураг төслийг БНХАУ-ын Шин Ян зураг төслийн судалгааны төвд хийлгүүлсэн байдаг. Нүүрс хуурай аргаар баяжуулах үйлдвэр нь 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс ажлаж эхэлсэн бөгөөд 2014-2015 онуудад тус үйлдвэрт суурилагдсан тоног төхөөрөмж болон үйлдвэрийн дэргэдэх лабораторидоо хагас үйлдвэрлэлийн туршилтын ажлыг дахин гүйцэтгэж үр дүнгийн тайланг бичсэн байна.

8. Нүүрсэнд хийсэн технологийн туршилтын үр дүнд түүхий нүүрсний чийглэгийн хэмжээ дунджаар 1.73%, дэгдэмхий бодисын хэмжээ дунджаар 20.4%, үнслэг дунджаар 30.3%, хүхрийн агуулга дунджаар 0.43%, G индекс дунджаар 66.5, илчлэгийн хэмжээ дунджаар 8428 кг/ккал байна. Хуурай баяжуулах үйлдвэрээс гарсан коксжих нүүрсний чийглэгийн хэмжээ дунджаар 2.06%, дэгдэмхий бодисын хэмжээ дунджаар 19.7%, үнслэг дунджаар 20.15%, хүхрийн агуулга дунджаар 0.43%, G индекс дунджаар 68.9, илчлэгийн хэмжээ дунджаар 6994 кг/ккал байна.

9. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ашиглалтын 1-15 дугаар жилүүдэд жилд дунджаар 2.8 сая.тн, ашиглалтын 16-25 дугаар жилүүдэд жилд дунджаар 2.5 сая.тн хүчин чадалтайгаар ажиллахаар байна. Үйлдвэр нь төсөл хэрэгжих 25 жилийн хугацаанд 61,767,000.00 тн түүхийн нүүрсийг хуурай аргаар баяжуулж 47,560,590.49 тн

G=20-65, G>65 дээш өсөх шинж чанартай ЧЗ болон Ч4 маркийн коксжих нүүрсийг гарган авна. Коксжих нүүрсний үнслэгийн хэмжээ нь 19.69-19.73%, илчлэгийн хэмжээ нь 6242-6239 кг/ккал, G индексийн хэмжээ нь 40-78% байна.

10. Хөшөөтийн нүүрсний ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэгч "МоЭнКо" ХХК нь байгаль орчин, нөхөн сэргээлтийн тухай Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана. Уг төслийн хэрэгжилтийн явцад 26.8 га талбай элэгдэл эвдрэлд өртсөн. Эвдэгдсэн талбайд холбогдох стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөө, техникийн болон биологийн нөхөн сэргээлт, хянан магадлагаа, үйлдвэрийн хаалтанд нийт 1,291.9 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна.

11. Үйлдвэрийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5914:2008, MNS 5917:2008, MNS5918:2008 Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, үржил шимт давхаргыг сэргээх үүднээс тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон олон наст ургамлын үр, навчит мод болон сөөг ургамал тарихаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төсөлд тусгасан байна. Байгаль орчин, хаалт, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэд анхаарч ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов. Уурхайн хаалтын төсөл хэрэгжүүлэхэд нийтдээ ашиглалтын хугацаанд 50 сая төгрөг зарцуулахаар байна.

12. Хөшөөтийн нүүрс баяжуулах үйлдвэр төслийн хүрээнд нийт орон тоогоор 144 хүнийг ажлын байраар хангаж, 1 ажилтны сарын дундаж цалин 1.8 сая төгрөг байна.

13. Төслийн цахилгаан хангамжийг ашиглалтын эхний жил суурилагдан ажиллаж байгаа дизель генераторуудаар хангана. Ашиглалтын 2 дахь жилээс Баруун бүсийн эрчим хүчний системээс хангана. Баруун бүсийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангахын тулд 110/35/10 кВ-н "Манхан" дэд станцын 110 кВ-н хувиарлах байгууламжийг өргөтгөж, төслийн талбай хүртэл 35 кВ-н шугам татаж ашиглана. Төслийн хүрээнд үүсч байгаа үйлдвэрийн талбайн орчмын тоос дарах болон галын усны хэрэглээг ил уурхайн шүүрэлтийн уснаас хангахаар төсөл тусгасан байна.

14. Төслийн хугацаанд нийт 679.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах ба үүний 301.5 тэрбум төгрөг нь балансын үлдэгдэл өртөг, 378.2 тэрбум төгрөг нь ашиглалтын үеийн нэмэлт хөрөнгө оруулалт бөгөөд төсөл хэрэгжих 25 жилийн хугацааны зцэст 6.9 тэрбум төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

15. 1 тн баяжуулсан нүүрсний дундаж бүрэн өөрийн өртөг 99.8 мянган төгрөг, 1 м³ уулын цул олборлох өртөг 16366.6 төгрөг байна. Нийт зардлын 36.9 хувийг олборлолт, 32.3 хувийг гадаад тээврийн зардал, 11.9 хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 8.2 хувийг татавар төлбөр, хураамж, 3.6 хувийг баяжуулах үйлдвэр, 0.9 хувийг байгаль орчин, нөхөн сэргээлтийн зардал 5 хувийг бусад зардлууд тус тус эзэлж байна.

16. 1 тн эрчим хүчний нүүрсийг (G=0-20) уурхайн амны нөхцөлөөр орон нутагт 16 ам доллар буюу 32000 төгрөгөөр, нүүрс баяжуулах үйлдвэрээс гарах коксжих нүүрсийг Ярантын боомт хүртэл тээвэрлэн, хил нөхцөлөөр ЧЗ маркийн (G=20-65) коксжих нүүрсийг 36 ам доллар буюу 72000 төгрөг, Ч4 маркийн (65<) коксжих нүүрсийг 68 ам доллар буюу 136000 төгрөгөөр зарж борлуулна.

17. Хөшөөтийн нүүрсний ордоос төслийн хугацаанд нийт магадласан үйлдвэрийн (В) зэрэглэлийн нөөц 84.36 сая.тн нүүрс олборлож үүнээс 47.6 сая.тн баяжуулсан нүүрс үйлдвэрлэн, 24.7 сая эрчим хүчний нүүрс худалдан борлуулах бөгөөд нийт 6.3 их наяд төгрөг, жилд дунджаар 253 тэрбум төгрөгийн борлуулалт хийнэ.

18. Үйл ажиллагааны мөнгөн урсгалаас хөрөнгө оруулалтын зардлыг хассан ашигт жилийн 10%-ийн дискаунтын (хорогдуулалт) нормоор бууруулан, өнөөгийн мөнгөнд шилжүүлсэн цэвэр ашгаар (NPV@10%) тооцвол 263 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 22.5% болж байна. Төслийн үргэлжлэх хугацаанд орж ирэх үйл ажиллагааны нийт мөнгөн урсгал нь 1,748.5 тэрбум төгрөг болох бөгөөд энэ нь нийт борлуулалтын орлогын 28%-тай тэнцэнэ.

19. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газар, ус ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад татвар хураамжийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоол, дүрэм, журмын дагуу тооцоолсон байна.

20. Хөшөөтийн нүүрсний төслөөс жилд дунджаар 31.5 тэрбум төгрөгийн татвар төлбөрийг хураамж байдлаар улс орон нутгийн төсөвт оруулах ба энэ нь борлуулалтын орлогын 12.5%-ийг эзлэхээр байна.

21. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг заан тэмдэглэж, эрсдэлээ багасгаж ажиллахыг ЭБМЗ-өөс анхааруулж байна.

22. ТЭЗҮ-ийн тодотголыг уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн төвшинд, чанар сайтай боловсруулж уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, цаашид хэрхэн ашиглаж нүүрс олборлох, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт үндсэн баримт бичиг болжээ.

23. Энэхүү техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХЯамны сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 тоот тушаалаар батлагдсан "Уул уурхайн төслийн ТЭЗҮ -д тавигдах шаардлага, хүлээн авах заавар"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргах тухай Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар шийдвэрлэв.

1. Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөт нэртэй MV-1414, MV-1640, MV-6525, MV-4322, MV-11887, MV-11888, MV-15289, MV-020299 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй нүүрсний ордын нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авав.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг энэхүү техник, эдийн

засгийн үндэслэлийн тодотголын дагуу ажиллуулж эхлэхийг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д анхааруулах.

3. Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу жил бүр уулын ажлын төлөвлөгөөг боловсруулж зохих газраар хянуулах, холбогдох бусад зөвшөөрлийг эрх бүхий бусад хуулийн этгээдээс авахыг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д даалгах, уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгохыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрөх.

4. ЭБМЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн салбар хуралдааны 16-15-05 дугаар дүгнэлтийн 12, 20, 21-т заасныг хэрэгжүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулж, байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилт, зардалд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т тус тус даалгах.

5. Техник, эдийн засгийн үндэслэлийг бичвэр, дискийн хамт ЭБМЗ-ийн дүгнэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Геологи мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөхийг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д даалгах.

6. Дүгнэлтийн 5-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д анхааруулах.

7. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг "МоЭнКо" ХХК (Ж.Оюунчимэг)-д, Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т тус тус даалгах.

8. "МоЭнКо" ХХК -ий захиалгаар Хөшөөтийн нүүрсний ордын нүүрс баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон ус хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ хөтөлбөр, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Геологи уул уурхайн зураг төсөл, судалгааны "Гложекс" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер Д.Эрдэнэчимэг хариуцна.

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БААТАРЦОГТ

БОЛОВСРУУЛСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.Маасүрэн

Д.МААСҮРЭН

**ХАВСРАЛТ 8. Байгаль орчны менежмент
төлөвлөгөөний биелэлтийн тайлан хүлээн авах
хяналтын хуудас**

ХАВСРАЛТ 9. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар

БАТЛАВ:

АРД ДААТГАЛ ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЦОГБАДРАХ



БАТЛАВ:

МӨЗНКО ХХК
ДЭД ЗАХИРАЛ Ж.ОЮУНЧИМЭГ



ДААТГАЛЫН ГЭРЭЭ

2020 оны 10 сарын 10-ны өдөр

№ D2020012085679 / М.С.Г. 0115-2020 Улаанбаатар хот

Нэг талаас 2062089 тоот регистрийн дугаартай АРД ДААТГАЛ ХК (цаашид Даатгагч гэх)-ийг төлөөлж ДААТГАЛЫН МЕНЕЖЕР О.МАЙБАЯР, нөгөө талаас 5141583 тоот регистрийн дугаартай МӨЗНКО ХХК-ийг төлөөлж ХАНГАМЖИЙН МЕНЕЖЕР Д.МУРАТ (цаашид Даатгуулагч гэх) нар дор дурдсан даатгалын гэрээг харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр байгуулав.

1) БРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. Төдөрхойлөлт

- 1.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр товчлоог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.1.1 **даатгагч** гэж Даатгалын тухай Монгол Улсын хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монгол улсын хуулийн этгээд болох Ард Даатгал ХХК-ийг;
 - 1.1.2 **даатгуулагч** гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын звйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
 - 1.1.3 **даатгалын зүйл** гэдэгт эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүрчлэн хуульд харшлагагүй эдийн бус ашиг сонирхлыг;
 - 1.1.4 **даатгалын эрсдэл** гэдэгт даатгалд хамрагдсан зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
 - 1.1.5 **даатгалын тохиолдол** гэж даатгуулсан звйлд даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
 - 1.1.6 **даатгалын хураамж** гэж даатгуулагч даатгалын звйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
 - 1.1.7 **даатгалын нөхөн төлбөр** гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын звйлд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;
 - 1.1.8 **даатгалын үнэлгээ** гэж даатгуулж байгаа эд хөрөнгийн болон эдийн бус ашиг сонирхлын мөнгөн нлэрхийллийн хэмжээг;
 - 1.1.9 **бүрэн сүйрэл** гэдэгт даатгалын зүйл нөхөн сэргээгдэх, засварлагдах боломжгүй буюу нөхөн сэргээгдэх зардал нь даатгалын үнэлгээнээс хэтэрсэн байх нөхцөл байдлыг;
 - 1.1.10 **өөрийн хүлээх хариуцлага** гэж даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгуулагчийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээ;
 - 1.1.11 **нөхөн сэргээх зардал** гэж даатгалын зүйл нөхөн сэргээгдэх, засварлагдахад гарах шууд зардлыг;
 - 1.1.12 **шууд бус зардал** гэж даатгалын тохиолдол бий болсоны улмаас даатгалын зүйлийг сэргээн засварлахтай холбогдон гарах нөхөн сэргээх зардлаас бусад зардлыг;
 - 1.1.13 **элэгдэл** гэж даатгалын зүйл нь хэвийн ашиглалтын явцад зөвхөн хугацаанаас хамааран хорогдсон өртгийг;
 - 1.1.14 **бодит үнэ** гэж нөхөн төлбөрийн үед даатгалын зүйлийг нөхөн сэргээх төлбөрөөс элэгдэл хассан үнийг тус тус ойлгоно.

Ард Даатгал ХК (МэЗөлбө ХХК) даатгалын гэрээ №: ДД020012025679

ХОЁР. Нийтлэг үндэслэл

- 2.1 Энэхүү гэрээгээр нэг талаас даатгуулагч нь энэхүү гэрээнд болон түүний хавсралтаанд дурдсан даатгалын зүйлийг даатгалын хэлбэрээр даатгуулж даатгалын хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгуулагчид нөхөн төлөх харилцааг зохицуулна.
- 2.2 Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 2.3 Энэхүү гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөлүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд талууд гэрээний Тусгай нөхцөлийг баримтлана.

ГУРАВ. Даатгалын гэрээний хугацаа

- 3.1 Энэхүү гэрээ нь 2020 оны 10 сарын 10-ны өдрийн 00 цагаас 2021 оны 10 сарын 09-ний өдрийн 24 цаг хүртэл хүчин төгөлдөр байна.
- 3.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 3.2.1 Хууль болон даатгалын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан;
 - 3.2.2 даатгагч эсхүл даатгуулагч дампуурсан, татан буугдсан;
 - 3.2.3 шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тогтоосон;
 - 3.2.4 даатгагдсан хөрөнгө шүүхийн шийдвэрээр хураагдсан;
 - 3.2.5 даатгалын хугацааг гэрээнд зааснаас өмнө дуусгавар болгохоор 2 тал тохиролцсон;
 - 3.2.6 даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.
- 3.3 Гэрээний хугацаа дуусмагц Талууд гэрээг цуцлах санал тавиагүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа бол энэхүү гэрээг гэрээний үндсэн хугацаагаар сунгагдсанд тооцно.

ДӨРӨВ. Даатгагчийн эрх

- 4.1 Даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
- 4.2 Даатгуулагчаас хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд өөрчлөлт оруулах санал тавих;
- 4.3 Даатгалын зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцах;
- 4.4 Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих;
- 4.5 Даатгалтай холбоотой шаардлагатай гэж үзсэн мэдээлэлийг даатгуулагчаас бүрэн хэмжээгээр гаргуулах;
- 4.6 Хууль болон гэрээнд заасан үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нөхөн төлөхөөс татгалзах

ТАВ. Даатгагчийн үүрэг

- 5.1 Даатгалын хууль тогтоомж, даатгалын нөхцөлүүдийг даатгуулагчид танилцуулах;
- 5.2 Монгол улсын хуульд зааснаас бусад тохиолдолд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг хадгалах, бусдад дамжуулахгүй байх;
- 5.3 Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх;
- 5.4 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгуулагчтай бүх талаар идэвхитэй хамтран ажиллах.
- 5.5 Ард Даатгал компанийн Ховд аймаг дахь салбар болон Ховд аймгийн Дарви сумын төлөөлөгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

Ард Даатгал ХК (МонЭко ХХК) баатгалын гэрээ №: 02020012005679

- 5.5.1 Учирсан хохирлыг газар дээр нь очиж зургаар баталгаажуулах
- 5.5.2 Даатгалын сургалт зөвлөгөө өгөх
- 5.5.3 Орон нутгийн удирдлагуудтай харилцаа холбоотой байж тус компанийг даатгалын асуудлаар төлөөлөн ажиллах
- 5.5.4 Нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх, Улаанбаатарт хүргүүлэх
- 5.5.5 Орон нутагт даатгалын тохиолдол учирсан үед Ард даатгал ХК-ний:
 - 5.5.5.1 Ховд аймаг дахь салбарын захирал холбогдох утас: 88101522

ЗУРГАА, Даатгуулагчийн эрх

- 6.1 Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
- 6.2 Даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 6.3 Даатгуулагчийн эрх үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
- 6.4 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадавхийн талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах;
- 6.5 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгагчтай бүх талаар иднхитэй хамтран ажиллах.
- 6.6 Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг зэрэг мэргэжлийн холбогдох байгууллагын хүмүүс оролцсон комисс томилж акт тогтоох
- 6.7 Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгагчаас шаардах;

ДОЛОО, Даатгуулагчийн үүрэг

- 7.1 Даатгалын хураамжийг энэхүү гэрээ батлагдсан өдрөөс доорхи хувиарийн дагуу даатгагчид тална. Үүнд:

	Төлбөр төлөх огноо	Төлбөр төлөх хэмжээ
1	2020.07.10	24,427,980
2	2020.11.02	9,172,566.5
3	2021.01.28	9,172,566.5
4	2021.04.28	9,172,566.5
5	2021.07.28	9,172,566.5

- 7.2 Даатгал болон даатгалын зүйлтэй холбоотой баримт, материал ба даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгагчид бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 180 хоногийн дотор хүлээлгэн өгөх;
- 7.3 Даатгалын зүйлийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор боловцоотой арга хэмжээ авах;
- 7.4 Даатгалын тохиолдол бий болсон болсон тухай даатгагчийн шуурхай албаны **77200088-(1)** утсаар холбогдож даатгалын тохиолдол болсоноос хойш 72 цагийн дотор урьдчилан мэдэгдэх (утас, факс, албан бичиг гэх мэт аль боломжтой арга хэлбэрээр);
- 7.5 Даатгалын тохиолдол бий болсон үед Даатгуулагч өөрийн зурдлаар шаардлагатай бүх мэдээлэл болон баримт бичгийг хангах;
- 7.6 Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох нэгдтэй нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон нөхцөл байдал болон даатгалын тохиолдол бий болох таагүй нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

- 7.7 Даатгалын зүйлийн өмчлөл, эзэмшилд өөрчлөлт орсон талаар даатгагчид 30 хоногт багтаан мэдэгдэж гэрээнд өөрчлөлт хийлгүүлэх.
- 7.8 Үйл ажиллагаа зогсох үед 15 хоногийн өмнө даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.

НАЙМ. Даатгалын нөхөн төлбөрийн ерөнхий нөхцөл

- 8.1 Даатгалын нөхөн төлбөрийг дараах материалыг үндэслэн олгоно. Үүнд:
 - 8.1.1 Даатгуулагчийн өргөдөл, хүсэлт;
 - 8.1.2 Даатгалын гэрээ, баталгааны хуулбар эсвэл хувь;
 - 8.1.3 Даатгалын тохиолдол бий болсныг нотлох фото зураг, боломжтой бол хэргийн газар дээрээс баталгаажуулсан бусад нотлох баримтууд, эд мөрийн баримтууд;
 - 8.1.4 Хохирлын шалтгаан, хэмжээ, зүйлийг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон акт, материал, баримт;
 - 8.1.5 Мэргэжлийн холбогдох байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт; шүүхийн шийдвэр;
- 8.2 Хохирлын хэмжээг тодорхойлохдоо эхлээд даатгуулагчийн гаргасан үнэлгээг харгалзан үзэх бөгөөд Даатгагч уг үнэлгээг үндэслэлгүй байна гэж үзвэл өөрөө хохирлын хэмжээг тодорхойлон Даатгуулагчтай зөвшилцөж болно. Талууд ийнхүү тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол улсад үнэлгээ хийх эрх бүхий үнэлгэгчин, аудитаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. Хэрэв уг үнэлгээг хүлээн зөвшөөрөх боломжгүй бол гуравдагч үнэлгээний байгууллагаар дахин үнэлүүлэх бөгөөд дахин үнэлүүлэхтэй холбогдсон зардлыг талууд хамтран хариуцна.
- 8.3 Энэхүү гэрээнд заасан хугацаанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаантай 30 хоногийн дотор Даатгуулагч даатгалын хураамжаа төлөөгүй байх үед даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын нөхөн төлбөрийг гэрээнд заагдсан хувь хэмжээгээр нөхөн төлөх эсэхийг даатгагч дангаар шийдэх ба хэрэв шийдвэл уг нөхөн төлбөрөөс талбал зохих нийт даатгалын хураамжийг суутган тооцно. Суутгалын дараа төлөгдөөгүй үлдсэн даатгалын хураамжийг хэрхэн төлөх талаар гэрээний талууд харилцан тохиролцоно.
- 8.4 Даатгалын тохиолдол болсон үед Даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан албан тушаалтан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн гэж хүлээн авч, зохих баримт үйлдсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хууль болон энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээнд олгоно. Хэрэв талууд нөхөн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцоогүй тохиолдолд энэхүү хугацааг ажлын 14 өдөр хүртэлх хугацаагаар сунгаж болно.
- 8.5 Хэрэв, даатгалын нөхөн төлбөртэй холбоотойгоор тухайн хэрэг төрийн захиргааны байгууллагад хянагдаж байгаа, шүүхийн журмаар хянан хэлэлцэгдэж байгаа нөхцөлд энэхүү гэрээний 8.4 дугаар зүйлд заасан зохицуулалт үйлчлэхгүй.
- 8.6 Даатгагчаас даатгуулагчид олгох нөхөн төлбөр болон хохирол бууруулах үйл ажиллагааны зардлын нийлбэр нь даатгалын үнэлгээнээс хэтэрч үл болно.
- 8.7 Даатгалын тохиолдол бий болсны дараа даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс талбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.
- 8.8 Даатгуулагч зохих журмын дагуу нөхөн төлбөрийг авснаас хойш гарсан хохирлоо буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн болох нь тогтоогдсон тохиолдолд даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг даатгагчид бүрэн буцаан төлнө.
- 8.9 Даатгуулагч нөхөн төлбөр авсаны дараа даатгалын үлдсэн хугацаан дахь даатгалын үнэлгээг сэргээгээгүй бол дараагийн нөхөн төлбөрийг олгохдоо даатгалын үлдэгдэл үнэлгээг зах зээлийн үнэнд харьцуулж хувь тэнцүүлэн тооцно.
- 8.10 Даатгуулагч энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөр авсан тохиолдолд даатгалын үнэлгээ мөнгүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд тухайн хэмжээгээр буурах бөгөөд Даатгагчтай харилцан тохиролцсон бол зохих хураамжийг төлсний үндсэн дээр даатгалын үнэлгээг дахин сэргээж болно.
- 8.11 Даатгалын тохиолдол бий болсны дараа талууд нөхөн төлбөрийг урьдчилсан байдлаар харилцан тохиролцон түүнээс тодорхой хувийг нь нөхөн төлбөр эцсийн байдлаар тогтоогдохоос өмнө даатгуулагчид олгож болно.

Ард Даатгал ХК (Монголын ХХК) дотоодын гэрээ №: 00920012085679

- 8.12 Даатгагчидтай тохиролцолгүйгээр даатгалын зүйлийг нөхөн сэргээсэн зардал нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл болохгүй.
- 8.13 Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг олгохоос татгалзах Үүнд:
- 8.13.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
- 8.13.2 Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 8.13.3 Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй, даатгалын гэрээнд тусгагдаагүй шалтгаан, эрсдэлийн улмаас хохирол гарсан;
- 8.13.4 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн буюу нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан
- 8.13.5 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 8.13.6 Даатгалын тохиолдлын үед эрсдэлийг таслан зогсоох арга хэмжээ аваагүй буюу хохирлыг санаатайгаар ихэсгэсэн нь тогтоогдсон бол (Эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсхүл энэхүү арга хэмжээг авснаар өөрт учрах хохирол нь эрсдэлээс учирч болох хохиролоос их болох нь илэрхий байвал энэ заалт хамаарахгүй.)
- 8.13.7 Гэрээнд өөрөөр заагаагүй бол нэмэлт эрсдэлийн улмаас үүдэн гарсан хохирол, нэмэлт зардал
- 8.14 Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзах.
- 8.14.1 Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна үүссэн хохирол
- 8.14.2 Даатгуулагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол
- 8.14.3 Хохирлоос үүдэн гарсан адийн засгийн алдагдал;
- 8.14.4 Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохирол;
- 8.14.5 Даатгалын зүйлийг гэмт хэргийн зорилгоор болон хууль бусаар ашиглаж явсан үед учирсан хохирол
- 8.14.6 Ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, бөмбөг дэлбэлэх, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
- 8.14.7 Техникийн бүрэн бүтэн байдал хангаагүй, ашиглалтын горимыг зөрчсөн, өөрчилсөн, эд ангийн зориулалт, даац ачаалаа хэтрүүлснээс үүссэн хохирол
- 8.14.8 Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол
- 8.14.9 Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй этгээдийн хийсэн аливаа үйлдлээс үүдэн гарсан аливаа хохирол
- 8.14.10 Даатгалын тохиолдлын бус үед зайлшгүй сэргээн засварлахтай холбогдон гарах зардал;
- 8.14.11 Даатгалын үнэлгээнээс давсан хохирол болон хохиролоос үүдсэн ашиг орлогын алдагдал;
- 8.14.12 Эд хөрөнгийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол гэмтэл;
- 8.14.13 Даатгуулагч даатгагчидтай тохиролцолгүйгээр хохирлыг арилгасан, нөхөн сэргээсэн нь хохиролын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд хохиролыг нөхөн төлөхгүй;
- 8.14.14 Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийн зөвшөөрөгдсөн байршил өөрчлөгдсөн, бусдад түрээслэх, барьцаалуулах, эзэлдүүлэх, ашиглуулах, тээвэрлэх мөн энэ тухай даатгагчид мэдэгдээгүй үед гарсан хохирол

8.14.15 Даатгалын зүйлийн өмчлөл, эзэмшилд өөрчлөлт орсон талаар даатгагчид 30 хоногт багтаан мэдэгдээгүй үед учирсан хохирол;

8.14.16 Даатгалын зүйлд зориулалтын бус болон тусгай зөвшөөрөлгүй тоноглол, төхөөрөмжийг нэмэлтээр суулгаснаас үүдэн гарсан аливаа хохирол, түүний үр дагавар болох нь тогтоогдсон бол

ЕС. Гэрээний нууцлал

- 9.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон Талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, Ноу-Хаут хугацаагүй чанд нууцалж, бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэйгээр хадгална.

АРАВ. Гэрээний хариуцлага

- 10.1 Хэрэв даатгагч энэхүү гэрээнд заасан журмын дагуу нөхөн төлбөрийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд ажлын хоног тутамд олгогдох нөхөн төлбөрийн 0.05 хувьтай тэнцүү хэмжээний алдангийг Даатгуулагчид төлнө.
- 10.2 Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй.
- 10.3 Даатгалын гэрээг дараах үндэслэлээр цуцална. Үүнд:
- 10.3.1 Даатгуулагч нь төлбөл зохих даатгалын хураамжийг төлөөгүй тохиолдолд Даатгагч гэрээг өөрийн санаачлагаар цуцлах эрхтэй;
- 10.3.2 Даатгуулагч даатгалын тохиолдол бий болох нөхцөлийг ихэсгэсэн, энэ талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй болох нь тогтоогдсон бол
- 10.3.3 Даатгалтай холбоотой баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хууль бус баримт бичиг бүрдүүлсэн;
- 10.3.4 Энэхүү гэрээний нууцлалыг задруулснаас гэрээний аль нэг талын ашиг сонирхолд хохирол учирсан буюу учирч болох нөхцөл байдал бүрдсэн;
- 10.3.5 Даатгагчийн санхүүгийн чадавхи илт буурсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тодорхойлогдсон.
- 10.4 Даатгалын гэрээ цуцлагдсанаас үүсэх үр дагавар
- 10.4.1 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээний нууцлалыг задруулсны улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 10.4.2 Даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүриэл даатгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр Даатгуулагчид буцаан төлнө. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд даатгалын нийт хураамжаас орлогод тооцсон хураамжийг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно.
- 10.4.3 Даатгуулагчийн санаачлагаар гэрээг цуцалбал даатгалын нийт хураамжаас орлогод тооцсон хураамжийг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед даатгуулагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд талууд биелэгдсэн үүргийн гүйцэтгэлийг харилцан бие биедээ бүрэн хэмжээгээр буцаан нөхөн төлнө.
- 10.4.4 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд гэрээнээс татгалзах тухай бичгэн мэдэгдлийг 1-ээс доошгүй сарын өмнө нөгөө талдаа өгнө. Гэрээний аль нэг тал гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзсанаас нөгөө талд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 10.4.5 Гэнэтийн буюу давагдангүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээг хүчин төгөлдөр болгох,

Ард Даатгал ХК (МОНЭКО ХХК) даатгалын гэрээ №: 02020012085679

- гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ.
- 10.5 Даатгагч болон даатгуулагч нь хамтын ажиллагааны хүрээнд тохиролцоо хийж болох ба энэ тохиолдолд даатгуулагч "Мэргэжлийн туслалцаа авах тухай мэдэгдэл"-ийг гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулан даатгагчид өгнө.
- 10.6 Энэхүү гэрээний хугацаа дуусмагц талууд уг гэрээг дүгнэж нэгдсэн дүгнэлт гаргаж ажиллана.
- 10.6.1 Уг дүгнэлтийг үндэслэн даатгалын гэрээг сунгахад Даатгагчийн зүгээс хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх эсвэл бууруулах саналыг гаргаж болно.

АРВАННЭГ. Талуудын албан ёсны хаяг

ДААТГАГЧ- Ард Даатгал ХК
Хаяг: Ард Санхүүгийн Нэгдлийн байр 2-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: 77200088; Факс: 77200089;
Холбоо барих хүний нэр: Даатгалын менежер О.Майбаяр
Гар утас: 88104408

ДААТГУУЛАГЧ – МОЭНКО ХХК
Хаяг: Түшиг төв-3 давхар, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Улаанбаатар-14250,
Монгол улс
Утас: 976 77110567
Факс: 976 77110570
Email хаяг: murat.da@mongolia-energy.com
Холбоо барих: Хангамжийн ахлах ажилтан Д.Мурат
Гар утас: 976 99056553

АРВАНХОЁР. Бусад зүйл

- 12.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 12.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.3 Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа асуудал, маргааныг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний талуудын эрх тэгш байдлын үндсэн дээр аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 12.4 Энэхүү гэрээг 18 хуудас бүхий 2 хува үйлдсэн бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

АРВАНДӨРӨВ. ЕРӨНХИЙ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

- 14.1 Энэхүү даатгалын хэлбэрт хэрэглэгдэх нэр томъёог дараахь байдлаар ойлгоно. Үүнд:
- 14.1.1 Ерөнхий хариуцлагын даатгал гэдэг нь даатгуулагчийн эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотой даатгуулагчийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндийн өмнө хүлээх хариуцлагын даатгал юм.
- 14.1.2 Шүүхийн зардал гэж шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдон гарах өмгөөлөлийн зардал, нотариатын хөлс, шинжээчийн зардал болон холбогдох зардлуудыг хэлнэ;
- 14.1.3 Тэмдэгтийн хураамж гэж шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.
- 14.1.4 Даатгалын зүйл гэдэгт даатгуулагчийн гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлага байна.

- 14.2 Ерөнхий хариуцлагын даатгалын үнэлгээ, хураамж, нөхцөл
- 14.2.1 Ерөнхий хариуцлагын даатгалын нийт үнэлгээ, хураамж дараах хэмжээтэй байна. Үүнд:

Хавсралт №	Даатгалын хэлбэр	Нийт үнэлгээ (төгрөг)	Хураамжын хэмжээ (төгрөг)
1	Ерөнхий хариуцлагын даатгал	2,000,000,000	Хураамж тооцохгүй
Нийт дүн		2,000,000,000	

Даатгалын нийт үнэлгээ: (хоёр тэрбум төгрөг)

- 14.2.2 Даатгуулагчийн нэр: МОЭНКО ХХК
- 14.2.3 Нийт хариуцлагын хэмжээ: 2,000,000,000 төгрөг
- 14.2.4 Даатгалын нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын хязгаар: 600,000,000 төгрөг хүртэл, үүнээс:
- 14.2.4.1 эд хөрөнгөний төлөө хүлээх хариуцлагын хязгаар: нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын 50 хүртэл хувь 300,000,000 төгрөг хүртэл
- 14.2.4.2 амь нас, эрүүл мэндийн төлөө хүлээх хариуцлагын хязгаар: нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын 50 хүртэл хувь буюу 300,000,000 төгрөг хүртэл
- 14.2.5 Даатгалын нэг удаагийн тохиолдлоор нэг хүнд ногдох хариуцлагын дээд хязгаар: 20,000,000 төгрөг хүртэл
- 14.2.6 Нэг удаагийн тохиолдолд даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг 2,000,000 төгрөг ба учирсан хохирлын 10 хувийн аль ихээр тооцно.
- 14.2.7 Даатгалын хамрах газар нутаг: Ховд аймаг, Дарви сум, Улаанбаатар хот, Монгол улс
- 14.3 Ерөнхий хариуцлагын даатгалын эрсдэл:
- 14.3.1 Даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой даатгуулагчийн санамсар болгоомжгүй үйлдэл, санаатай бус үйл ажиллагааны улмаас
- 14.3.1.1 Бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулах

Ард Даатгал ХК (МэЭвКө ХХК) даатгалын гэрээ №: D2620012085679

- 14.3.1.2 Бусдын эд хөрөнгөд хохирол учруулах
- 14.3.1.3 Нэмэлт зардлын даатгал: Даатгагч нь даатгалын тохиолдлын дараа бий болсон баримтаар нотлогдсон 500,000 төгрөг хүртэлх нэмэлт зардлыг /үнэлгээний болон ослын газраас зөөн тээвэрлэх зардал, аюулыг зайлуулах зардал/ дааттуулагчид төлнө.
- 14.4 Ерөнхий хариуцлагын даатгалын нөхөн төлбөр
- 14.4.1 Даатгалын хугацаанд бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохиролд олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь даатгалын гэрээнд заасан нийт хариуцлагын хэмжээгээр хязгаарлагдана.
- 14.4.2 Даатгагч нь даатгалын нэг удаагийн тохиолдлын нэхэмжлэлд дурьдсан бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохирлыг энэхүү гэрээгээр тохирсон даатгалын нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын хязгаарт багтаан барагдуулна.
- 14.4.3 Монгол улсын шүүхийн шийдвэр, эрх бүхий байгууллагын тогтоосон хохирлын актыг, тэмдэгтийн хураамжийг хуульд заасан хэмжээгээр, шүүхийн зардлыг жишиг тарифийг үндэслэн тус тус тооцож хохирлыг барагдуулна.
- 14.4.4 Эд хөрөнгийн хохирлыг зах зээлийн үнэлгээгээр тооцсон, баримтаар нотлогдож буй нөхөн сэргээх, засварлах зардлыг нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын хязгаарт багтаан олгоно.
- 14.4.5 Олгохоор тооцсон нөхөн төлбөрөөс дааттуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын дүнг хасч олгоно.
- 14.4.6 Даатгагчаас дааттуулагчид олгох нөхөн төлбөр болон хохирол бууруулах үйл ажиллагааны зардлын нийлбэр нь даатгалын нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын хязгаараас хэтэрч үл болно.
- 14.4.7 Хохиролд өртсөн зүйл бүрэн сүйрсэн гэж үзэж, даатгагч нь даатгалын нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр олгосон тохиолдолд тухайн сүйрсэн зүйлийн өмчлөгч нь өмчлөх эрхээ даатгагчид шилжүүлнэ.
- 14.4.8 Даатгалын тохиолдол болсон үед хохиролд орсон зүйлийг аюулаас зайлуулах, хадгалж хамгаалах талаар тодорхой арга хэмжээ аваагүй бол хэсэгчлэн төлнө.
- 14.4.9 Даатгалын нэг удаагийн тохиолдлын хохирлын нэхэмжлэл нь хоёр ба түүнээс дээш хохирогчтой ба хохирлын хэмжээ нь даатгагдсан нэг удаагийн тохиолдлоор хүлээх хариуцлагын дүнгээс давсан тохиолдолд уг хариуцлагын хязгаарт багтаан хувь тэнцүүлэн хувиарлалт хийж нөхөн төлбөрийг төлнө.
- 14.4.10 Тухайн нэхэмжлэлд нэг хүний эрүүл мэндэд учирсан хохиролд олгож болох дээд хэмжээ нь нэг удаагийн тохиолдлоор нэг хүнд ногдох хариуцлагын хязгаартай тэнцүү байна.
- 14.4.11 Бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг хохирогчийн нэхэмжлэлийн талаар гаргасан шүүхийн шийдвэр болон дотоодын эмчилгээ үйлчилгээний тарифаар тооцсон баримтаар нотлогдох эмчилгээ үйлчилгээний зардлын дүнгээр нөхөн олгоно.
- 14.4.12 Нөхөн төлбөр олгох нотолгоо баримт бүрдүүлээгүй бол нөхөн төлбөрийг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:
- 14.4.12.1 Дааттуулагчийн буруугаар хохирогч этгээд нас барах, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах тохиолдолд даатгалын нэг удаагийн тохиолдлоор нэг хүнд ногдох хариуцлагын хязгаарт багтаан 100 хувиар нөхөн төлбөр олгоно.
- 14.4.12.2 Хохирогч нь хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол дааттуулагчийн эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн (эмнэлгийн байгууллагын тодорхойлолт хэрэв тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон бол тэтгэврийн дэвтэр зэргийг үндэслэн) хуанлийн өдрөөр тооцсон хугацаанаас хамааруулан дор дурьдсан хувиар хариуцлагын хязгаараас бодож нөхөн төлбөр олгоно. Үүнд:
- а. 45 хүртэл хоногийн хугацаагаар эмчлүүлсэн хуанлийн хоног тутамд 0,3 хувь;

